



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр, Баасан гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-8</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>9-50</i>

<b>Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах</b>	10-11
<b>1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.07.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	11-27
<b>2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</b>	28-29
<b>3. Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай</b>	29-37
<b>4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалт</b>	37-38
<b>5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн санал хураалт</b>	38
<b>6. Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлын санал хураалтаар үргэлжлэв.</b>	38
<b>7. Хуулийн төслийг эцэслэн батлах</b>	39
<b>8. Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт, тогтоолын төсөл</b>	39-50
<b>9. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт</b>	50

**Монгол Улсын 2025 оны намрын ээлжит чуулганы  
12 дугаар сарын 19-ний өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 20 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Б.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, А.Ганбаатар, С.Лүндэг, П.Мөнхтулга, Г.Очирбат, Б.Тулга, Г.Хосбаяр;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Ч.Анар, Х.Ганхуяг, Г.Дамдинням, С.Зулпхар, Т.Мөнхсайхан, М.Нарантуяа-Нара, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Л.Гантөмөр, П.Сайнзориг, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн, Ө.Шижир, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Х.Баттулга, Э.Болормаа, Ц.Даваасүрэн, Б.Жаргалан, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-15 минут, Н.Алтаншагай-52 минут, Х.Баасанжаргал-35 минут, Ц.Баатархүү-31 минут, Д.Батбаяр-1 цаг 35 минут, Н.Батсүмбэрэл-1 цаг 00 минут, П.Батчимэг-26 минут, Э.Батшугар-1 цаг 36 минут, Ж.Галбадрах-30 минут, Г.Ганбаатар-20 минут, Д.Ганбат-28 минут, Т.Доржханд-11 минут, Б.Жавхлан-1 цаг 05 минут, Д.Жаргалсайхан-1 цаг 44 минут, Ц.Мөнхбат-1 цаг 37 минут, Ц.Мөнхтуяа-12 минут, Б.Найдалаа-03 минут, П.Наранбаяр-07 минут, Б.Пунсалмаа-2 цаг 11 минут, О.Саранчулуун-15 минут, Ц.Туваан-1 цаг 30 минут, Б.Түвшин-02 минут, А.Ундраа-27 минут, Ч.Ундррам-17 минут, Г.Уянгахишиг-04 минут, Д.Цогтбаатар-16 минут, Б.Энхбаяр-15 минут, Ж.Энхбаяр-14 минут, Д.Энхтуяа-32 минут.

**Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын 3 гишүүнээс 2025.12.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Европын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.12.18-ны өдөр өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

***Нэг.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.07.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчны хэлтсийн дарга Ж.Батзолбоо, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх С.Сайнбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Батжаргал, Н.Наранбаатар, Да.Цогтбаатар, Ж.Батсуурь, Л.Соронзонболд, Б.Түвшин, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, С.Эрдэнэболд нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:24/*

***Хоёр.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, мөн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Лхагвацэнд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын

албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:30/*

**Гурав.Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Улсын ерөнхий прокурорын орлогчид нэр дэвшигч М.Чинбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Алтангэрэл, Ж.Золжаргал, Л.Соронзонболд, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад нэр дэвшигч М.Чинбат хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:00/*

**Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

**Н.Учрал:** 1.Байнгын хорооны саналаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47  
Татгалзсан: 45  
Бүгд: 92  
51.1 хувийн саналаар дэмжигдлээ.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

2.Байнгын хорооны саналаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 42  
Бүгд: 92  
54.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

***Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн санал хураалтаар үргэлжлэв.***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

**Н.Учрал:** Байнгын хорооны саналаар Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57  
Татгалзсан: 35  
Бүгд: 92  
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.*

***Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлын санал хураалтаар үргэлжлэв.***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

**Н.Учрал:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор Максимын Чинбатыг томилох асуудлыг зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 27  
Бүгд: 92  
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 71.7 хувийн саналаар дэмжигдлээ.*

Санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэхээр тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв.Хуулийн төслийг эцэслэн батлах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

**Н.Учрал:** Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 47  
Татгалзсан: 45  
Бүгд: 92  
51.1 хувийн саналаар эцэслэн батлах санал дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг эцэслэн батлах саналыг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов.

*Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт, тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг нар байлцав.

Түр хорооны тайланг Улсын Их Хурлын гишүүн, түр хорооны дарга О.Батнайрамдал танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Х.Тэмүүжин, О.Батнайрамдал, С.Бямбацогт, П.Ганзориг нар үг хэлж, уг асуудлыг дахин түр хороо болон Байнгын хороогоор хэлэлцэх шаардлагатай тул хойшлуулах санал гаргав.

*Улсын Их Хурлын дарга Н.Учрал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4-т “нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно.” гэж заасны дагуу буцаав./12:52/*

***Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтаар үргэлжлэв.***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

***Хамт өргөн мэдүүлсэн:***

**Н.Учрал:** Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 65  
Бүгд: 94

30.9 хувийн саналаар эцэслэн батлах санал дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг эцэслэн батлах саналыг дэмжээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцов.

*Уг асуудлыг 12 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгаас Улаанбаатар хотод суралцдаг оюутан, залуучуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн урилгаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Төрийн өмчит компанийн Улаанбаатар салбарын инженер, диспетчерүүдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, С.Амарсайхан нарын урилгаар Налайх дүүргийн Ерөнхий боловсролын 103 дугаар сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын

урилгаар Сэлэнгэ аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ компанийн ажилчдын төлөөлөл, Нийслэлийн ерөнхий боловсролын 102 дугаар сургуулийн 12<sup>а</sup>, 12<sup>б</sup> ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 2 цаг 35 минут үргэлжилж, 126 гишүүнээс 94 гишүүн хүрэлцэн ирж, 74.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 55 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр, Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 20 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Н.Учрал:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. 48 гишүүн ирсэн байна. Өнөөдөр Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан 2025 оны 7 дугаар сарын 04-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн холбогдуулан боловсруулсан хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийнэ.

Мөн Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

4 дүгээр асуудал Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

5.Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцэнэ. Оюутолгойн хянан шалгах түр хорооны сонголт зохион байгуулагдсантай холбогдуулж санал, дүгнэлтийг хэлэлцэнэ.

Төсгөлд нь Улсын Их Хурлын дэд даргыг шинээр томилсонтой холбогдуулаад Монголын парламентын бүлгэмийн гүйцэтгэх хорооны даргыг томилох санал хураалт явуулна. Олон улсын парламентын холбоо, Монгол Улсын Их Хурлын дэд дарга олон улсын парламентын холбоо дээр Монголын парламентын бүлгэмийн гүйцэтгэх хороог тэргүүлж ажилладаг. Ингээд парламентын бүлгэмийн гүйцэтгэх хорооны даргыг шинээр томилоод, парламентын бүлгэмийн гүйцэтгэх хороо дээр 2 улсын парламентын дарга нарын бүрэлдэхүүнийг шинээр баталж, олон улсын парламентын холбоонд хүргүүлж, парламентын хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх чиглэлээр ажиллаад, анхны парламентын бүлгэмийн гүйцэтгэх хорооны хурлыг шинэ дэд дарга томилогдсонтой холбогдуулж хийнэ. Өнөөдрийн хэлэлцэх асуудлууд бол энэ хүрээнд хэлэлцэгдэнэ гэдгийг та бүхэнд хэлье.

Ирэх 7 хоногт бол Их Хурлын гишүүдийн ирцийг бүрдүүлэх дээр бас онцгой анхаарах хэрэгтэй. Ирэх 7 хоногт Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлуудыг шийдвэрлэнэ. Ингээд хэлэлцэх эсэх дэмжигдсэнтэй холбогдуулаад Их Хурлын гишүүд ажлын хэсгийг ахална. Олон нийтийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулна. Гишүүдийг танхимд уръя. Санал хураалтаар эхэлнэ.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулсан.

1 дүгээрт Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэн явуулна.

2-т Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

3 дугаарт Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

4 дүгээрт Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

5 дугаарт Хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал, дүгнэлт, Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал, Хассуурийн Ганхуяг, Заяабал нарын 3 гишүүн 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

2.“Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улс болон Европын сэргээн босголт хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй хамтран боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд тус тус хуваарилсан болно.

Бямбацогт сайд, Энхбаяр сайд, Батшугар сайд нарыг дуудвал Бүгд Найрамдах Франц Улсын Гадаад худалдааны яамнаас өчигдөр нөгөө хиймэл дагуулын төслийг 100 хувь нэн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхийг Францын Засгийн газар шийдвэрлэсэн гэдэг албан бичгийг Их Хурлын даргын нэр дээр Засгийн газарт хүргүүлсэн байна лээ. Тэгээд өнгөрсөн хугацаанд манай Инновацын дэд хорооны дарга Анарын бас Францад очиж ажилласны үр дүнд энэ төсөл нэн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх нь дэмжигдсэн. Тэгээд энэ бол их сайн ийм шийдвэр боллоо. Тэгэхээр Засгийн газар нэн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхийг дэмжсэнтэй холбогдуулаад зээлийн хэлэлцээрийг Их Хуралд өргөн мэдүүлэх боломжтой. Тэгэхээр Засгийн газар энийгээ шийдвэрлээрэй гэдгийг хэлье. Тийм, нэн хөнгөлөлттэй 100 хувь нэн хөнгөлөлттэй зээлээр явуулна гэдгээ шийдвэрлэсэн байна лээ. Их Хурлын гишүүд нөгөө Францад очиж ажилласны дараа.

Ингээд Байнгын хороонд Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хуваарилсныг та бүхэнд танилцууллаа.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

**Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.**

Эдийн засгийн байнгын хороо, энийг даргын зөвлөл дээр бас ярья. Эсвэл бусад Байнгын хорооноос санал, дүгнэлт аваад, одоо Зөвшөөрлийн хуультай холбогдуулаад Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Гэхдээ Хууль зүйн байнгын хороо санал, дүгнэлт гаргах бас шаардлагатай байх гэж үзэж байна. Тэгэхээр Тэмүүжин гишүүний энэ саналыг бас даргын зөвлөл дээр яриад, бид нар Хууль зүйн байнгын хороо дээр санал, дүгнэлт аваад, Эдийн засгийн байнгын хороо нэгтгээд оруулъя гэдэг Тэмүүжин гишүүний саналыг тусгаж байна. Эдийн засгийн байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороонд хуваариллаа.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хууль санаачлагчийн илтгэлийг Жуковын Алдаржавхлан гишүүн танилцуулна. Индэрт урья.

**Ж.Алдаржавхлан:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Миний бие санаачлан боловсруулсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Улаанбаатар хотын барилга, авто замын бүтээн байгуулалтад ашиглаж байгаа хайрга, дайргыг нийслэлийн нутаг дэвсгэрээс тодруулбал, Туул голын сав газраас ихээр олборлож байна. Энэ байдал нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байгаа бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь жилээс жилд нэмэгдэж байна.

Тус хуулийн төслийг боловсруулахдаа иргэдийн санал, хүсэлт, Монгол Улсын Засгийн газраас түгээмэл ашигт малтмалын олборлолт явуулснаас эвдэрч доройтсон газрын талаарх статистик мэдээлэл, мөн энэ чиглэлээр авсан арга хэмжээний талаарх мэдээллийг тус тус авсан болно.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээс харахад улсын хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтоос ухагдаж эвдэрсэн газрын хэмжээ 2021 оны байдлаар 11319 га байна. Энэ дотор нийслэл Улаанбаатар хотод 2404 га газар эвдэрч, доройтсон байна.

Усны газраас ирүүлсэн мэдээллээр Туул голын сав газар, түүний дотор нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт явуулснаас эвдэрч доройтсон газрын хэмжээ 5137 га газар байна.

Гол мөрний ус бүрэлдэх эх усны сан бүхий газрын хамгаалалтын бүс ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль батлагдсаны дараа Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтооход хамгаалалтын бүс давхцалтай 46 аж ахуйн нэгжийн 2950 га газрын тусгай зөвшөөрлийг цуцалж шийдвэрлэсэн боловч тухайн газрууд нөхөн сэргээлт огт хийлгүй орхисон байна.

Цаашдаа усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, олборлох, ашиглах зөвшөөрөл олгохгүй байх, одоо үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг үе шатаар хязгаарлах бөгөөд энэ чиглэлээр эрх зүйн орчныг эргэн харах зайлшгүй шаардлага үүссэн тул энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Тодруулбал, хуулийн төслийн 29.4-д орон нутгийн байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатын Засаг дарга нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа талаарх гомдлыг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хэлүүлэх хүсэлтийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана гэж хуульчилснаар эрх ашиг нь хөндөгдөж буюу зөрчигдөж буй иргэдээс гаргасан гомдлыг эрх бүхий байгууллага хүлээн авч хэлэлцэх байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийх эрх зүйн орчин бүрдэж байгаа юм.

2-т түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа талаар дүгнэлт гарсан бол түүнийг цуцлах, зориулалт зохицуулалтыг мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5 дахь хэсэгт нэмж тусгалаа.

Энэхүү хуулийн үндсэн үзэл санаа нь ашигт малтмалын олборлолтын бүсэд амьдарч буй, эрх нь зөрчигдөж байгаа иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршиж байгаа юм.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

**Н.Учрал:** Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна.

**Л.Соронзонболд:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлангаас 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөл санаачлагч нь усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, олгогдсон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх үндэслэл, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар дүгнэлт гарсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой харилцааг нарийвчлан, тодорхой зохицуулах шаардлагад үндэслэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байхтай холбоотой зохицуулалт болон хуулийн төслийн орон нутгийн байгаль хамгаалагч Байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатын Засаг дарга нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа талаарх гомдлыг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх тухай хүсэлтийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана гэсэн заалт нь Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл заалттай давхардаж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Шинэбаярын Бямбасүрэн усан сан бүхий газрын хил хязгаарыг хэрхэн тогтоодог, мөн орон нутагт элс, хайрга, дайрга олборлохдоо зөвшөөрөл авахгүй ашиглаж байгаа асуудлыг хэрхэн зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар хуулийн төсөлд түгээмэл тархацтай гэж заасан нь бусад ашигт малтмалыг олборлох, ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулахад хязгаарлалт үүсэх эсэх, орон нутагт бүрэн бүтээн байгуулалт хийхэд шаардагдах хайрга, дайрга олборлох тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Сэддорж нийслэл дэх Дархан цаазат газрын хил хязгаарт ямар нэг өөрчлөлт орох, тусгай хамгаалалтаас гаргах зэрэг эрсдэл үүсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Сэддорж ашигт малтмал олборлох, боловсруулах явцад өртөж эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийхтэй холбоотой хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлыг анхаарах талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 65 хувь, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 70 хувийн саналаар

хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Н.Учрал:** Соронзонболд гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Сүрэнхүүгийн Сайнбаяр Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Жүгдэрбарамын Батзолбоо Нийслэлийн Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчны хэлтсийн дарга. Ажлын хэсгийг танилцууллаа.

Мэндчилгээ танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 102 дугаар сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад өмнө нь урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Түвшин гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна. Пүрэвдорж гишүүн нэрээ татсан байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Энэ хуулийг хэлэлцэхийг бол дэмжиж байгаа. Гэхдээ энэ Түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль дээр өөр шийдвэрлэх ёстой олон зүйл байгаа. Ялангуяа орон нутагт энэ бол их зовлон болсон хууль шүү дээ. Ажил явуулъя гэхээр тухайн ажил хариуцсан хүн бол бараг хуулийн байгууллагад шалгагдаад, цаашаа яваад өгөх хэмжээний олон зохицуулалтууд нь шал дутуу. Бүх юмыг ингээд төвдөө төвлөрүүлчихсэн ийм зүйл. Ганцхан улсын чанартай зам тавихад тэнд шаардлагатай байгаа шороог хаанаас авах вэ гэдгийг маш олон шат дамжлага дамжиж, дамжиж тэгээд Засгийн газар дээр эцсийн байдлаар шийддэг. Энэ нь өөрөө манай бүтээн байгуулалтын цаг хугацаа, олон юмнуудтай харшилддаг юм байгаа юм. Тэгэхээр энийг бол болимоор байгаа юм. Сумын даргын зовлон байна. Суманд нь улсын төсвийн хөрөнгөөр 1 цэцэрлэг барих болдог. Хайргаа хаанаас өгөхөө мэдэхээ байдаг. Ингээд л аймаг руу явдаг, яам руу явдаг, эргээд өнөөх нь баахан шат дамжлага дамжаад буцаж ирэх болдог. Энэ хооронд маш их цаг хугацаа алддаг. Цагаа алдахгүйн тулд хайргаа авхуулчихаар Засаг дарга өөрөө шоронд явчих гээд байдаг. Экологийн асуудал гээд маш хүнд ялтай ийм асуудал руу орчих гээд байдаг гээд энэ цөөхөн барилгынхаа хугацаанд ажлаа явуулахад маш хүндрэлтэй ийм зүйл байгаа.

Ялангуяа түгээмэл дээр нэг их зовлонтой юм байгаа нь юу вэ гэхээр ер нь жирийн айл нэг хаяаны манааны шороогоо авчихад л ер нь шоронд явчих хэмжээнд оччихсон ийм муухай хатуу зохицуулалттай. Тэгээд маш их шат дамжлага дамжсан. Тэгээд аймаг, сумын Иргэдийн Хурлыг эрх мэдлийг нь бууруулсан. Тэгээд л ердөө

шууд дээрээ л бүх юмаа шийднэ гэдэг ийм маш хүнд хууль байгаа юм. Тэгэхээр энийг хэлэлцэх эсэхийг нь бол дэмжиж байгаа. Энэ агуулгуудыг бас оруулмаар юм шиг санагдаад байдаг юм.

Одоо энэ чинь 2 дахь асуудал бол ашигт малтмалын төлбөр ашигласны төлбөрийг тухайн компани тендерт шалгарахдаа тэдэн төгрөгөөр бид нар тооцож тушаана гэж хэлчхээд, яг амьдрал дээр тушаадаггүй. Тэгээд л нөгөө сумын дарга, байгаль орчны байцаагч 2 энийгээ тушаачхаач гээд л гуйгаад л байна. Хогийг чинь цэвэрлээд бартердаад өгье л гэнэ. Маш зовлонтой. Тэгэхээр ер нь бол энэ түгээмэлд гар хүрч байгаа бол хэдүүлээ хүрсэн шиг хүрээд, саяын энэ сумын зовлон, энэ аймгийн зовлон, энэ бүх зүйлүүдийг нь цэгцлээд, төсөв дээр өгөх ёстой мөнгийг нь заавал сумын дарга, байгаль орчны байцаагчаар биш энэ төсвөөс нь шууд сумынх нь төсөв рүү ороод явчихдаг гэдэг ийм жоохон зохицуулалт хийж, энэ хуулийг жоохон амьдралд буулгах шаардлагатай байгаа юм гэж ингэж харж байгаа юм. Тэгээд тухайн үед яагаад ингээд ийм айхтар хатуу хууль гаргачхав гэхээр нэг зовлон яриад байдаг. Түгээмэл тархацтай ашигт малтмалаар халхавчилж алт ухдаг гэж яриад байгаа юм. Үгүй ээ, тэр чинь ердөө хэдхэн аймаг л байгаа шүү дээ. Хангайн аймаг, Архангайн Өвөрхангай, Төв аймаг. Үгүй ээ, энэ хавиар л алт ухаж байгаа болохоос өөр бусад сумаар түгээмлээр халхавчилж алт ухаад байгаа газар мэдэхгүй. Тэгэхээр 1 ажлыг хаах гэж байгаа юм гэж улс даяар ийм хүнд суртлын схем болгочихсон, маш их шат дамжлага болгочихсон. Төрийн байгууллагаасаа эхлээд жирийн иргэн хаяа манааны шороогоо хүртэл авч чадахгүй байдалд аваачаад хаячихсан энэ хуулийг бол би нэлээн сайн цэгцлэх нь зүйтэй гэж ингэж бас үзэж байгаа юм.

Тэгэхээр энэ ингээд хэлэлцэх эсэх нь дэмжигдээд, цаашаа явахаараа ажлын хэсэг гараад энэ аймаг, сумын Иргэдийн Хуралд нь бас тодорхой эрх мэдлийг нь өгөөд, ёстой тэгээд түгээмлийн нэрээр алт ухаад байдаг юмыг аймгийн Хурал зөвшөөрсөн бол тэр хариуцлага тэндээ хүлээгээд явдаг ийм механизм руугаа орохгүй бол энэ маш зовлонтой юм байгаа. Энэ бол тэгээд тэр голын ай сав газар гээд Улаанбаатар хотод зовлон бол зөндөө байгаа. Энийгээ ч бас давхар шийдээд энэ хуулийг бүр жоохон хөрсөн дээр нь буулгаад, төрийн ажил явуулж байгаа шат шатын Засаг дарга, Иргэдийн Хурлын хариуцлага, харилцааг нь бүр тодорхой /минут дуусав/

**Н.Учрал:** Санал хэллээ. Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Гишүүдийн амар амгаланг айлтгая. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд нь дэмжье. Гэхдээ энэ түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай асуудлыг ер нь бид зөв зохицуулахгүй бол үнэхээрийн болохгүй байгаад байгаа юм. Орон нутгийн ажил амьдралд тун шаардлагатай энэ түгээмэл тархацтай зүйлсийг ашиглах гэхээр зэрэг зөвшөөрлийнх нь асуудал хүндрээд байдаг. Бас цаг хугацааныхаа хувьд бүтээн байгуулалтын ажлуудаа шуурхай явуулъя гээд асуудалд хандахаар зэрэг орон нутгийн улс төрөө дийлж өгөхгүй, хэдэн биеийгээ зөрүүлж энд тэнд матаад, үндсэндээ үүний золиос болж нэг хэсэг орон нутгийн удирдлагуудад асуудал үүсээд болж өгөхгүй байгаа юм.

Улсын чанартай авто замын бүтээн байгуулалт л нэлээн олон шат дамжлага дамжиж байж асуудал нь шийдэгдэж байгаа болохоос биш орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлууд энэ тэр дээр бол энэ

түгээмэл тархацтай ашигт малтмалыг үнэхээрийн ашиглаж чадахгүй байгаа. Тийм учраас би энэ Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга юм уу, энэ нэмэлт, өөрчлөлт орж ирэхдээ энэ харилцаагаа бүрэн зохицуулах талаас нь холбогдох салбарууд анхаарлаа хандуулж ажилламаар байна. Тэгэхгүй болохоор зэрэг энэ асуудал нь бүтээн байгуулалтынхаа ажлыг удаашруулдаг, хүндрүүлдэг ийм нөхцөл байдлуудыг үүсгээд байна. Тэгээд одоо нэгэнт нэмэлт, өөрчлөлт ороод ирж байгаа учраас хөндөгдөөгүй заалт гээд өөр асуудлуудыг ярих гэхээр зэрэг хязгаарлагдчихаад болж өгөхгүй байна л даа. Тэгэхээр зэрэг тодорхой гишүүд бас энэ төвөгтэй асуудлуудыг нь шийдэх талаар нэмэлт, өөрчлөлтийн төсөл өргөн мэдүүлж, хамтатгаж хэлэлцэх ёстой юм уу. Үүнийг бас бид зөв харж, зөв шийдэх тухай асуудал байгаад байна гэдгийг зориуд хэлмээр байна.

2 дахь асуудал. Улаанбаатар иргэдийнхээ экологийнхоо нөхцөл байдлыг бодоод өөрийнхөө бүтээн байгуулалтад өөрийнхөө нутаг дэвсгэрээс юм авахгүй гэвэл хил залгаад, тойроод байж байгаагаараа Төв аймаг юм өгөх бололтой юм. Тэгээд энэ асуудлыг бас зөв харах ёстой. Үнэхээрийн энэ барилга байгууламж, бүтээн байгуулалтад чинь голын элс, хайрга нь стандартынхаа хувьд үнэхээрийн нийцэж байгаа юм уу, үгүй юм уу. Нэг хэсэг нь бол нийцэж өгөхгүй байгаа гэдэг юм яриад байгаа. Хэрвээ тийм байгаа бол тэр дүгнэлт юмнуудаа мэргэжлийн байгууллагууд нь гаргаад, тэр дайрга ашиглах хэлбэр лүүгээ шилжмээр байгаа юм. Энэ бол яах аргагүй мэргэжлийн, технологийн, тэгээд бий болж байгаа бүтээн байгуулалтын чанар насжилтын асуудалдаа нэлээн том чухал зүйл. Энэ дээр манай хуулийн төсөл санаачлагч хийсэн судалгаа, дүгнэлт энэ тэр юмнууд байна уу. Энэ дээр би тодорхой хариулт авчихъя.

**Н.Учрал:** Энэ түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл одоогийн Зөвшөөрлийн хуулиар бол тусгай зөвшөөрөлд хамаарагдаж байгаа. Сая Заяабал гишүүн, Ганхуяг гишүүн бид 3-ын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн хууль дээр энэ зөвшөөрөл энгийн зөвшөөрөл болж байгаа. Тэгэхээр ер нь бол хүнд суртал буурахад энэ Зөвшөөрлийн хууль бол нэлээд дөхөм болно. Тэгэхээр зөвхөн Эдийн засгийн байнгын хороогоор биш хэлэлцэх эсэхээ дэмжихээд ер нь бараг бүх Байнгын хороогоор санал, дүгнэлтүүдийг нь түрүүн Тэмүүжин гишүүний хэлдгээр авбал нөгөө салбарын асуудлуудаа тухайлан тухайлан яриад явахад их нэмэртэй байх гэж бодож байна. Тэгээд Алдаржавхлан гишүүн хариулъя. Батжаргал гишүүн бас чухал асуудлыг хөндөөд байна. Одоо байгаа тусгай зөвшөөрөл байгаа шүү дээ. Түүнийг нь энгийн зөвшөөрөл болгож Зөвшөөрлийн хуульд оруулж ирж байгаа. Алдаржавхлан гишүүн хариулъя.

**Ж.Алдаржавхлан:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ хууль бол зөвхөн Улаанбаатар хот биш Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөх хууль байгаа. Зүгээр энэ хууль яагаад санаачлах болов гээд би бас ганц хоёрхон зургийг та хэдэд харуулах гээд аваад ирсэн юм. Одоо ингээд Туул гол руу баруун тийшээ гаргах юм бол ийм дайн болчихсон юм шиг байгаа. 46 аж ахуйн нэгж олборлоод, ингээд хаяад явчихсан. Тэгээд иргэдийн хашаатай бүр ингээд тулчихсан байж байгаа юм. Шувуун фабрикийн айлуудын хашаанд нь тулаад, хайрга олборлож байгаа. Тэгэхээр энэ асуудлыг шийдэхгүй бол иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчин бүрдэхгүй байгаа учраас энэ хуулийг санаачилсан. Энэ хууль ерөөсөө хамгийн гол үзэл санаа нь иргэний эрхийг хамгаалахад оршиж байгаа юм.

Батжаргал гишүүний асуултад хариулахад тусгай зөвшөөрлийн асуудлууд дээр хуучин бол юу яадаг байсан юм байна лээ. Цуцлахад байгаль орчны

үнэлгээний сөрөг нөлөөллийн дүгнэлт гарч байгаад цуцална гэдэг шаардлага огт байхгүй байсан. Тэгээд энэ хуульд иргэн хэрвээ гомдол гаргах юм бол байгаль орчны нөлөөлөл үүсэж байгаа талаарх дүгнэлтийг Байгаль орчны яам гаргаад, түүнийг үндэслэн цуцлах эрх нь бүрдэж байгаа юм. Тусгай зөвшөөрлийг хөнгөвчлөх асуудлыг би дэмжиж байгаа. Идэрбат гишүүн энэ тэр ярьж байгаа асуудлыг бид нар ажлын хэсэг гаргаад, дараа дараачийнхаа асуудлаар ороод явахад дэмжиж байна. Энийг хөнгөвчлөх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Тусгай зөвшөөрөл нь өөрөө хатуу байхаар хулгайгаар ухдаг асуудал маш их болсон. Аймаг, орон нутагт. Тийм учраас энийг хөнгөвчлөх асуудал бол нэн чухал байгаа юм гэдэг дээр санал нэг байна.

**Н.Учрал:** Батжаргал гишүүн тодруулах уу. Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асуун.

**Н.Наранбаатар:** Тэгээд энэ хуулийн төсөл яг энэ чигээрээ батлагдах юм бол хөдөө орон нутагт, ялангуяа сумд бол бүтээн байгуулалтын ажил хийж болохооргүй л болчхоод байгаа юм. Ялангуяа энэ говийн жижиг сумд чинь сумынхаа дэргэд байгаа тэр сайраас л хайрга авч байгаа шүү дээ. Тэгээд л ёстой хаяаныхаа манаасыг, тэгээд хувийнхаа орон сууцыг барих, цаашлах юм бол цэцэрлэг, сургууль гээд. Тэгээд энэ усны сав газар гэгчээр тэр сумын хажуугаар явж байгаа тэр сайр чинь бол орчхож байгаа юм. Усны сав газар. Жилийн 4 улиралд ус урсдаггүй ч гэсэн бороо хуртай жил ус урсдаг гол болоод л явчихдаг байхгүй юу. Тэгээд энийг нь хаагаад хаячих л юм байна лээ энийг харахаар зэрэг.

Тэгэхээр энэ хууль бол нийслэл Улаанбаатар хотод Туул голыг хамгаалахтай холбоотой л гол зорилго нь байна гэж би ойлгоод байгаа юм. Тэгэхээр Улаанбаатар хотод бол тохироод, хөдөө орон нутагт бол энэ хууль хэрвээ хэрэгжээд явбал тохирохгүй юм байна. Хэрвээ энэ хууль хэрэгжээд ингээд явдаг. Сумынхан бүтээн байгуулалтаа хийгээд явдаг, баахан хүмүүс хууль зөрчсөн болоод, ингээд хэрэгтэн болоод л явах ийм юм руу орчихоор. Нөгөө талаасаа бүтээн байгуулалтын ажлууд хойшлохоор, нөгөө талаасаа мөн бүтээн байгуулалтын ажлын төсөв нэмэгдэх ийм асуудлууд л гарчхаад байх юм. Тэгээд энийг хууль санаачлагч, ажлын хэсэг хэр судалсан байгаа юм. Орон нутгийн асуудлыг хэр судалсан юм байгаа юм. Энэ дээр хариулт авч байгаад, дараа нь тодруулаадахъя даа.

**Н.Учрал:** Алдаржавхлан гишүүн хариулна.

**Ж.Алдаржавхлан:** Наранбаатар гишүүн Усны тухай хуулиар одоо ч хүртэл усны голын хамгаалалтын бүс гээд 250 метр байгаа шүү дээ. Тэндээс янз бүрийн ашигт малтмал олборлохыг бүрэн хориглочихсон байж байгаа байхгүй юу. Одоо ч тэр сайраас авч болохгүй, хуулиар хориотой юм. Ер нь зүгээр бүтээн байгуулалт зогсоно гэж байгаа юм. Тэгэхдээ бүтээн байгуулалт ямар нөхцөлд ашигтай вэ гэвэл цэвэр уулын хайрга, дайрга олборлосон нөхцөлд бүтээн байгуулалт хамгийн чанартай болох юм билээ. Голын хайрга бол ер нь бол тийм ч сайн зүйл биш гэж үзэж байгаа.

Ерөөсөө энэ хуулийн үндсэн санаа нь Наранбаатар гишүүн ээ. Тэр орон нутаг гэхээсээ илүү яг энэ уул уурхайн ашигт малтмалын олборлолтын бүсэд амьдарч байгаа иргэд хэрвээ өөрөө өөрийнхөө орчинд ямар нэгэн ашигт малтмал буюу хайрга дайрга олборлуулахыг хүсэхгүй байвал, өөрийнх нь эрхийг нь зөрчиж байвал тэр гомдлыг гаргах эрх нь нээгдэж байгаа. Хуучин тийм юм байхгүй байсан юм байна

лээ. Тэгээд 1 байгаль хамгаалагч, улсын байцаагч хортой нөхцөл үүсвэл зогсооно гэсэн заалт Байгаль хамгаалах хууль дээр байгаа. Тэр нь тэгэхдээ хортой нөхцөл гэдэг нь яг юуг хэлэх вэ гэдэг нь бас тодорхойгүй. Тийм учраас байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ хийлгүүлэх заалтыг оруулж ирснээрээ иргэн өөрөө гомдол гаргах тэр эрх нь үүсэж байгаа учраас иргэний эрх талаас их том, чухал зүйл болж байгаа юм. Яах вэ, тэгээд ажлын хэсэг гаргаад ажиллаж байх явцад бас Наранбаатар гишүүний саналыг аваад ярилцаж бас болох байх гэж бодож байна. Орон нутгийн асуудал дээр яаж хандах энэ тэрийг бас ярилцаж болох байх гэж бодож байна.

**Н.Учрал:** Наранбаатар гишүүн тодруулна.

**Н.Наранбаатар:** Амьдрал дээр сумын иргэд уулын толгой дээр очоод тэсэлгээ хийгээд, дэлбэлээд дайрга олборлоно гэж бол байхгүй. Сумын дэргэдэх тэр хайргыг л ашиглаж байгаа шүү дээ. Тэгээд суманд чинь ямар 10, 20-оос дээш давхар байшин баригдаад байх биш. Энэ бол амьдрал. Сумынхаа дэргэдээс л жаахан шороо, хайрга авч байгаа юм.

2-т гэвэл заавал ийм хууль гаргахгүйгээр одоо байгаа энэ хууль, эрх зүйн орчин чинь угаасаа та хэлж байна шүү дээ. Зохицуулчихсан л байгаа байхгүй юу. Урт нэртэй хууль гээд. Тэгээд энэ хуулиуд чинь одоо хэрэгжүүлээд явчихвал болохгүй юу. Аль эсвэл нийслэлийн Иргэдийн Хурлаас тогтоол гаргаад энэ Туул голтой холбоотой, Био комбинаттай холбоотой асуудлаа шийдэж болохгүй юу. Говийн сумаас гадна бас хангайн сумд ч байгаа шүү дээ. Усны сав газар, усандаа ойрхон хангайн сумд, ойдоо ойрхон сумд байгаа шүү дээ. Тэд нар бас бүтээн байгуулалт нь ..../минут дуусав/

**Н.Учрал:** Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Энэ бол зайлшгүй хэрэгтэй хууль байгаа юм. Зүгээр одоо ч тэр урт нэртэй хуулиар чинь хайрга, дайргыг голын усны сав газраас олборлохыг хориглочихсон л байгаа шүү дээ. Энэ хууль гарч ирээд хориглож байгаа юм бол байхгүй. Шинээр хориглож байгаа юм ерөөсөө байхгүй. Зүгээр бид нар иргэдийн эрхийг нээж өгч байгаа, иргэний эрх талаасаа их том хууль болж байна гэж үзэж байгаа. Яах вэ бусад зүйлүүд дээр би Наранбаатар гишүүнд хэлээд байна. Тэгээд ажлын хэсэг дээр хэдүүлээ бас ярилцъя. Орон нутагтай холбоотой асуудлуудыг.

**Н.Учрал:** Даваагийн Цогтбаатар гишүүн.

**Да.Цогтбаатар:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Ардын намын дарга, Улсын Их Хурлын дарга Учрал дарга аа, танай нам Удирдах зөвлөлөөрөө хэлэлцээд, сайд нь завгүй үед Улсын Их Хурлын чуулганд асуултад хариулдаг их л чухал ажил, албан тушаал гэж хэлээд 16 сайд томилсон. Одоо энэ Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын гишүүн өргөн бариад, хэлэлцээд явъя гэхээр тэнд би лав сайд болж харахгүй байна. Уул уурхайн сайд чинь ч алга байна. Бөөн зардал чирэгдэл болоод, данхар төр бий болгож байгаад томилсон дэд сайд чинь ч алга байна. Энэ дээр та Улсын Их Хурлын дарга гэдэг зарчмынхаа байр суурь дээр байж байгаад жоохон хариуцлагатай байлгахгүй бол сүүлдээ 1 хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн орж ирээд Улсын Их Хуралд чинь асуулт хариултад хариулах гэж байна гэдгийг анхаараад өгөөч.

Тэгээд ер нь бол салбарын уялдаа холбоо ерөөсөө байдаггүй. Яг энэ асуудалтайгаа холбоотой ярихад. Бөөн асуудал болж болж Уул уурхайн яам яах вэ Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар лиценз олгоё гээд олгоод явуулдаг. Нөгөөдөх нь нийслэл дээрээ давхцал гарчихдаг. Ямар ч уялдаа холбоо байдаггүй. Энэ уялдаа холбооны чиглэлд И-Монгол гэдэг юм уу, цахим Монгол гэдэг юм уу бөөн юм болоод яваад байдаг тэр байгууллагууд нь датануудаа нэгтгэдэг юм уу, мэдээллүүдээ нэгтгэх чиглэлд ажиллахгүй бол асуудал тэнд очоод гацчихдаг. Өнөөдрийг болтол ер нь тийм л байгаа. Тэгээд энэ ажил чинь урагшаа явж чадахгүй. Сүүлдээ энэ нийслэлийн зовлонтой байдлыг шийдэхийн тулд нийслэлээс сонгогдсон гишүүд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг өргөн барьж байгаа байх.

Ер нь зүгээр ашигт малтмал гээд ярихад энэ нийгэмд дагуулдаг хар сэртэй асуудал чинь ерөөсөө тэр шүү дээ. Хайгуулын ч бай, ашиглалтын ч бай 1 тусгай зөвшөөрөл өгдөг. Тэгээд бодит байдал дээрээ очоод хайх ажлаа хийе, ашиглах, ажлаа хийе гээд очихоор хайлгадаг ч үгүй, ашиглуулдаг ч үгүй, баахан байгаль хамгаалагч нар гараад ирдэг. Ухуулна, ухуулахгүй, хортой, хоргүй гээд бөөн асуудал ярьдаг. Зүгээр яг ингээд төр лицензээ ашиглалтын ч бай, хайгуулын ч бай лицензээ өгч байгаа бол яг лицензийн эзэн ийм ажлаа хий, орон нутаг энэ ажлаа хий, иргэд энэ хяналтаа тавь. Ухуулна, ухуулахгүй гэдгээ лиценз өгөхөөсөө өмнө шийдээд өгчихсөнийхөө дараа бол ажлуудыг нь хийлгэхгүй бол Монгол Улс хүссэн, хүсээгүй уул уурхайн орон. Тэгээд энэ дээрээ бид нар асуудлаа шийдээд явж чадахгүй юм бол одоо нийгэмд гараад харахад Тавантолгой, Эрдэнэт дээр л ингээд лицензийн маргаан байхгүй байх шиг байна. Тэрнээс Оюутолгойгоосоо өгсүүлээд л хайгуулын шинэ лиценз хүртэл бүгдээрээ лицензийн маргаантай, ажлаа хийж чаддаггүй. Тэгэхээр энэ асуудлуудаа шийдэх чиглэлд энэ уул уурхайн сайд, дэд сайдтай чинь ярья гэхээр хэнтэй ярих юм. Ийм хариуцлагагүй Улсын Их Хурал байх юм бол энэ чинь бас их л хариуцлагагүй байдал руу орох гээд байна шүү дээ Их Хурлын дарга аа. Зүгээр яг энэ хэлэлцэж байгаа бол асуудалтай холбоотой бол уялдаа холбоогоо сайжруул гэдэг санал хэлье.

**Н.Учрал:** Цогтбаатар гишүүн ээ, энэ Их Хурлын гишүүн Алдаржавхлангийн санаачилсан хууль Байнгын хороогоор энэ хууль орохдоо тус ажлын хэсэгт төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох байгууллагаас ямар албан тушаалтнуудыг оруулах вэ гэдгээрээ нэр өгч байгаа шүү дээ. Тийм биз дээ. Тамгын газрынхан. Тэгээд энэ чинь нөгөө Их Хурлын гишүүний санаачилсан хууль Байнгын хороон дээр энэ дэд сайд, төрийн нарийн энэ төрийн нэрийг нь өг л дөө. Тэгээд нөгөө Засгийн газраас санаачлаагүй хууль учраас гээд Их Хурлын гишүүн өөрөө энэ хуулийг боловсруулсан. Өөрийнхөө багийнхныг өөрийнхөө зөвлөхийг, тэгээд энэ хууль дээр ажилласан багийнхныг ингээд ажлын хэсэг гээд оруулаад ирчихсэн байна шүү дээ. Тийм биз дээ Алдараа дарга аа, та тэгж оруулж ирсэн юм байна шүү. Тэрийгээ зөвөөр ойлгоорой. Хэрвээ Алдаржавхлан дарга, дээрээс нь энэ Байнгын хороон дээр яамныхныг, агентлагийнхныг оруулж ирэх шаардлагатай гэвэл нэрээ өгөөд оруулж ир. Энэ дээр сайдыг нь дуудах уу, дэд сайдыг нь дуудах уу гээд ажлын хэсэг дээр бол оруулж ирэх хэрэгтэй шүү. Цогтбаатар гишүүний шаардлага зөв. Гэхдээ яг дэгээрээ бол Их Хурлын гишүүн хууль санаачлахдаа хууль дээр ажилласан багаа ажлын хэсэгтээ оруулаад, ингээд асуултад хариулуулж байгаа. Сайнаа доктор жишээ нь хариулаад байна шүү дээ зөвлөхийн хувиар. Тэгээд хэрвээ яам, агентлагаас холбогдох албан тушаалтнууд орж асуултад хариулах хэрэгтэй бол Байнгын хороон дээр нэрийг нь чуулганаар оруулж ирэх хэрэгтэй. Ер нь Их Хурлын гишүүн санаачилсан ч бай холбогдох сайд нар нь заавал орж ирэх хэрэгтэй

шүү дээ. Цогтбаатар гишүүний яриад байгаа шаардлага зөв. Тэгэхээр Алдраа дарга та өөрөө юу гэж үзэж байгаа юм. Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

**Ж.Алдаржавхлан:** Үгүй ээ, би Цогтбаатар гишүүнтэй санал 1 байна. Би энэ Батбаатар гэдэг сайдтай холбогдоод, би ийм хууль өргөн барих гээд байна. Хоёулаа хамтарч ажиллая гээд, би байгаль хамгаалах, усны эхийг хамгаалах хууль санаачилж байна гэсэн. Гадаадаар яваад олддоггүй юм байна лээ. Миний утсыг аваагүй, мессежинд би гадаадад байна гэж хариу өгсөн. Би бараг Байгаль орчны сайдын ажил хийсэн сая хэсэг хугацаанд. Энэ хуулийг хийх гэж. Тэгээд энэ хүн ер нь олдоогүй шүү надад. Би зүгээр шулуухан хэлчихье.

**Н.Учрал:** Манай Алдараа дарга бол үнэхээр хувийн зохион байгуулалт өндөртэй, хариуцлагатай хүн шүү. Эрч хүчтэй. Ер нь аливаа ажлыг дааж авсан бол ард нь гардаг, хариуцлагатай гишүүн гэдгийг би бас тодотгож хэлье. Олонхын бүлгийн гишүүдэд тодотгон хэлье. Жамбын Батсуурь гишүүн асуулт асууна.

**Ж.Батсуурь:** Бүгдэд нь өдрийн мэнд. Тэгэхээр түгээмэл тархацтай ашигт малтмалыг ярьж байгаа асуудлыг бол сууриар нь өөрчлөх ёстой гэж ингэж үзэж байгаа юм. Орон нутагт, ер нь Монгол Улсын хэмжээнд эдийн засгийг, хөрөнгө оруулалтыг боомилж байгаа гол асуудлын нэг бол энэ. Энэ бол юу вэ гэхээр эрх мэдлийг хэт төвлөрүүлэн татсантай холбоотой Учрал сайд аа, хэт төвлөрүүлэн татсан. Үнэхээр аймгууд чинь яг ард иргэдээсээ сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэж мундаг газар байна. Хяналтыг нь Засгийн газар булаагаад авчихсан. Эрхийг нь Засгийн газар булаагаад авчихсан. Энийг саяын Учрал даргын хэлдгээр тэр тусгай зөвшөөрлийг нь энгийн зөвшөөрөл болгох ёстой. Хэд хэдэн том суурь өөрчлөлт хийхгүй бол энэ цаашаа явахгүй. Барилгын ажил, замын ажил, орон сууцны ажил, бүтээн байгуулалтын ажил.

Жишээлэх юм бол, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг харьяа яаманд нь өгөх ёстой. Энийг Засгийн газар дээр байх ямар ч шаардлага байхгүй. Дээр нь Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын харьяа агентлагийг аймгийн Засаг дарга, Иргэдийн Хуралд нь мэдлийг нь өгөх ёстой. Ингэж байж цогцоороо асуудал шийдэгдэнэ. Тэгэхгүй бол Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуульд 1 заалт оруулснаар бол энэ асуудал үндсэндээ шийдэгдэхгүй. Би Наранбаатар гишүүнтэй бол санал 1 байна. Энэ эрх мэдлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нь өгчих юм бол би сумд өгөхгүй өгчихвөл арай жижгэрэх байх гэж бодож байна. Бас тэнд асуудал үүснэ. Аймагтайгаа холбогдож чадахгүй сум гэж бол байхгүй. Тийм учраас яг хаанаасаа хайргаа өгөх юм, хаанаасаа дайргаа өгөх юм, хаанаасаа усаа өгөх юм, хаанаа бутлуур карьераа бий болгох юм гэдгийг бүх сумдаасаа сонгогдсон аймгийнхаа иргэдийн Хурал дээр яриад, ийм цогц бодлого хэрэгжүүлээд, үүнийгээ нэгдсэн хяналтыг нь орон нутагт нь өгөх ийм л арга замыг шийдвэрлэхгүйгээр энэ бол цаашаа явахгүй.

Мэдээж Алдаржавхлан гишүүн өөрийнхөө тойрогт гэдэг юм уу, Улаанбаатар хотын Туул голтой холбоотой асуудлыг сэтгэл нь зовж байгаад асуудлыг 1 л өнцгөөс нь харж байна. Тийм учраас би бол бараг Их Хурлын дарга Засгийн газарт үүрэг, чиглэл өгөөд, энэ агентлагийн асуудлыг байх газар нь аваачаад, орон нутагт очих агентлагийг нь байх газар нь аваачаад ерөөсөө аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэж тэр том байгууллагын шүд, хумс хаздаг, хайрдаг юмыг нь бүгдийг Засгийн газар, Их Хурал татаад авчихсан.

Ер нь бол 1992 оны Үндсэн хуулийн дараа орох хамгийн том хууль бол нутгийн захиргааны өөрөө удирдах ёсны байгууллага байсан. Энийг ерөөсөө бүх талаас нь мөлжсөөр байж байгаад, ерөөсөө тэнд 30-аад хүнийг ямар ч эрх мэдэл байхгүй, эндээс очсон төсвийг баталдаг. Тэрийгээ тойрог дээрээ булаацалдаад, жоохон муудаад, сайдаж муудсан ийм л хэмжээний юм болгочихсон. Тийм учраас нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад нь энийг өгчих юм бол бүх асуудал бүрнээрээ шийдэгдэнэ дарга аа.

Дээр нь энэ Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг ерөөсөө Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд нь өг. Мөн тэр харьяа агентлагийн хянах, шийдэх агентлагийг нь орон нутгийн Засаг даргад нь өгөх л юм бол энэ асуудал иж бүрнээрээ шийдэгдэнэ. Алдаржавхлан гишүүний ярьж байгаа бол нэг л талаас нь харж байгаа санал бодол болохоос биш энэ бүтнээр нь шийдэх боломж бол байхгүй. Тийм учраас энэ тусгай зөвшөөрлийг нь энгийн зөвшөөрөл болго. Энгийн зөвшөөрлийн асуудлыг нь шууд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нь өгснөөр энэ асуудал бүрэн дүүрэн шийдэгдэнэ. Тийм болохоор цогцоор нь асуудлыг авч шийдэхийг бас би Их Хурлын даргаас хүсэж байна. Баярлалаа.

**Н.Учрал:** Батсуурь гишүүний саналыг бол би бүрэн дэмжиж байна. Засгийн газарт бид бас хамтдаа ажиллаж байсан. Энэ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын зохион байгуулалтыг өөрчлөхгүй бол цаашдаа амьдрал дээр нийцэхгүй байгаа. Одоо 90 хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл ирэх 7 хоногт хэлэлцэнэ. Зөвшөөрлийн хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах. Тэгээд энэ түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг тусгайд байлгахгүй. Энгийн зөвшөөрөл рүү шилжүүлнэ. Нийслэлийн худалдаа үйлчилгээний бүх зөвшөөрөл нэргүй ч гэсэн бүртгэл нэртэй хориглолтуудыг бүгдийг нь мэдэгдэл болгоно. Нэг ёсондоо бол Их Хурлын даргын захирамжаар энийг чөлөөлье гэдэг санаачилга хэрэгжүүлнэ. Одоо чөлөөлөлт хийнэ. Түүний эхлэл болгоод 90 хуулиар зах зээл дэх төрийн оролцоог багасгах, аж ахуйн нэгжүүдэд үүсээд байгаа энэ хүндрэл саадуудыг арилгах хууль, эрх зүйн чөлөөлөлтийг хийнэ. Тэгэхээр энэ чөлөөлье гэдэг санаачилгыг манай парламентын гишүүд, улс төрийн нам эвсэл хамаарахгүйгээр дэмжинэ гэж итгэлтэй байна. Тэгээд үүн дээр Батсуурь сайдыг идэвхийлэн оролцоно гэж итгэж байна. Кдоо энэ дээр Алдаржавхлан гишүүн хариулаад, та тодруулна. Алдаржавхлан гишүүн хариулт өгье.

**Ж.Алдаржавхлан:** Батсуурь гишүүний саналыг бол ойлгож байгаа. Тусгай зөвшөөрөлтэй асуудал яг тантай санал нэг байгаа. Тэгээд хэдүүлээ гэхдээ энэ хуулиа Батсуурь гишүүн ээ, иргэний эрхтэй холбоотой олон заалт байгаа юм. Тэрийгээ хэдүүлээ батлах ёстой. Одоо ашигт малтмалын олборлолтын бүсэд амьдарч байгаа иргэн гомдол гаргах эрх, түүнийгээ дүгнэлт гаргах эрх нь байхгүй байгаа юм. Энийг бид нар гаргаж өгөх зайлшгүй шаардлага байгаа. Энэ талаас нь хуулийнхаа энэ заалтуудыг батлаад явах ёстой. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал дээр бол санал 1 байна. Бүрэн дүүрэн санал нэг байна гэдгээ бас илэрхийлье.

**Н.Учрал:** Батсуурь гишүүн тодруулъя.

**Ж.Батсуурь:** Үгүй ээ, яах вэ ер нь ийм л юм болоод байгаа юм л даа. Энэ хуулиудыг жижиг жижиг нүдээр хараад, жижиг жижиг эрх ашгаар явсаар байж байгаад Үндсэн хуулийнхаа үндсэн агуулга концепцыг бүр эвдээд, танигдахын тухай болгоод байгаа юм. Ер нь одоо бид нар асуудалд зоригтой хандах ёстой. Зоригтой

хандаж иж бүрэн ул сууриар нь асуудлыг шийддэг болох ёстой. Жишээлэх юм бол энэ түгээмэл тархацтай асуудал аягүй жижиг юм шиг боловч Төсвийн тухай хууль магадлалтай энэ тэр нөгөө гол хэрүүлийн чинь амин сүнс байдаг. Яагаад вэ гэхээр 1 сумд 1 соёлын төв оччихдог. Жоохон зам, цэцэрлэг, сургуулийн асуудал оччихдог. Тэгээд тэнд хүмүүс шоронд орохгүйн тулд сая Наранбаатарын гишүүний хэлснээр тэр хайрга, даргиа авч чадахгүй, зөвшөөрөл авахын тулд 200км-300км-ээс хайрга татаж байгаа байхгүй юу. 200км, 300км-ээс хайрга дайрга татахаар нөгөө төсөв ямар болох вэ. Нэг талаасаа .../минут дуусав/

**Н.Учрал:** Батсуурь гишүүнд нэмэлт 1 минут.

**Ж.Батсуурь:** Нэг талаасаа бүтээн байгуулалт хийж байгаад тендерт орсон компаниуд хууль зөрчихгүй, хэрэг төвөгт орохгүйг хичээнэ. Тэгэнгүүт хуулийнх нь дагуу бүтээн байгуулалтаа хий гэнгүүт төсөвт өртөг нь нөгөө хэлээд байгаа 2 дахин, 3 дахин өснө. Тийм болохоор Баян-Өлгий аймагт барьж байгаа цэцэрлэгийн үнэ Хөвсгөл аймагт барьж байгаа цэцэрлэгийн үнэ, говьд барьж байгаа цэцэрлэгийн үнэ бол эрс тэс өөр үнэтэй гарч ирж байгаа юм. Тэрийг гаднаас нь хараад яаж байна вэ гэхээр тэр магадлал хийсэн хүмүүс, аудит хийсэн хүмүүст буруу тохоод байгаа болохоос тэр яг суурь үндэслэл нь болонгуут ерөөсөө л материалын үнэ, зай талбай, орцын асуудал байж байгаа байхгүй юу. Тийм учраас одоо энэ тусгай зөвшөөрлийг энгийн зөвшөөрөл олгох орон нутагт нь эрх мэдлийг нь л өгчих юм бол ерөөсөө энэ асуудал чинь байгаль орчин талаасаа ч тэр өртөг талаасаа ч тэр, хяналт талаасаа ч тэр иж бүрнээрээ шийдэгдэнэ дарга аа.

**Н.Учрал:** Батсуурь сайд маш зөв санаачилга гаргаж хэлж байна шүү. Тэгэхээр энэ чөлөөлье гэдэг энэ санаачилгын хүрээнд Батсуурь сайдыг идэвхийлэн оролцуулна. Алдаржавхлан дарга байна. Ер нь энэ зах зээлийг дэмждэг, төрийн оролцоог бууруулья гэдэг бодолтой хүмүүсийг олон болгохын төлөө ажиллах хэрэгтэй. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууна.

**Л.Соронзонболд:** Би Алдаржавхлан гишүүний санаачилсан төслийг бол байгаль орчин талаас нь ер нь бол дэмжиж байгаа. Гэхдээ одоо яг Улаанбаатар хотод бас үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд бизнес эрхлэгчид байгаад байдаг. Тэгээд тэр хүмүүс жишээлбэл, яг голын ай сав газар биш өөр газар очоод үйл ажиллагаа явуулья гэхээр нөгөө зөвшөөрлөө авах гээд дахиад бараг 1 жил гаруй хугацаа шаарддаг. Энэ хооронд нь барилгын төслүүд нь ажлууд нь удна гээд түрүүний гишүүдийн яриад байгаа асуудлууд үүснэ. Тэгэхээр энэ асуудлыг ер нь Алдаржавхлан гишүүн энэ төсөл дээр ер нь яаж шийдвэрлэе гэж бодсон бэ.

Дээрээс нь бол энэ хэрэгжиж эхлэх хугацаа дээр яг тодорхой хугацаа нь хэзээнээс, батлагдсанаасаа эхэлж явах юм уу. Мөрдөгдөх юм уу. Яаж тооцож байгаа юм.

**Н.Учрал:** Алдаржавхлан гишүүн хариулья.

**Ж.Алдаржавхлан:** Бүтээн байгуулалттай холбоотой хайрга дайргын олборлолт бол явж байгаа шүү дээ. Уулын дайрга олборлох ажил Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт бүгдэд нь явж байгаа. Налайх орчимд явж байна. Шувуун фабрик, Биокомбинат, Өлзийт орчимд бас уулын дайрга олборлох ажлууд явж байгаа. Тэрэнд бол энэ хууль огт хамаарахгүй. Зөвхөн голын ай сав газар гэж байгаа. Мөн суурьшлын бүс гэж байгаа. Би та нарт сая 1 зураг үзүүлсэн. Та хэд

маань анзаарч харахгүй л байх шиг байна. Одоо жишээ нь Шувуун фабрикийн айлын хашааных нь хажууд ухаж байгаа байхгүй юу. Суурьшлын бүсээс жоохон холдуулъя л гэж байгаа юм. Энэ чинь хүний эрхийн асуудал, иргэний эрхийн асуудал ярьж байгаа юм. Тийм учраас тэр талаас нь хараарай. Тэрнээс биш бусад дайрга олборлож байгаа, уулын дайрга олборлож байгаа Улаанбаатар хотын бүтээн байгуулалтад оролцож байгаа компанид огт нөлөө байхгүй. Голын хайрга олборлохыг бол Улаанбаатарын нөхцөлд Туул голын ай сав газарт бол хориглох нь зүйтэй. Ер нь урт нэртэй хуулиар ч хориглочихсон байгаа шүү дээ. Тэгээд тэнд үүсчихсэн нөхөн сэргээлтийн асуудлыг бид нар бас гаргаж тавих ёстой. Зүгээр хаячихсан байгаа байхгүй юу. 46 аж ахуйн нэгж газар зүгээр дэлбэлээд хаячихсан. Үүний араас бид нар явах ёстой учраас энэ хуулийг санаачилсан. Тэгэхээр нийслэл хотын бүтээн байгуулалт болон бусад бүтээн байгуулалтад дайрга олборлоход ямар ч нөлөө байхгүй гэдгийг бас тодотгож хэлье.

**Н.Учрал:** Тэгээд энэ Зөвшөөрлийн хуулиар тусгай зөвшөөрөлд хамаарагдчихаар хугацаа тодорхойгүй байдалтай байгаа байхгүй юу. Хэрвээ Зөвшөөрлийн хууль дээр энгийн зөвшөөрөл олгочихвол зөвшөөрөл хүсээд ажлын 22 өдөр билүү, 30 өдөр нь дуусчихвал шууд эхэл гэдэг. Зөвшөөрлийн хуулийн концепц тэр шүү дээ. Энгийн зөвшөөрөлд хамаарагдаж байвал хуулийн хугацаа дуусвал шууд үйл ажиллагаагаа эхэл гэж байгаа юм. Төр хариуг нь өгөөгүй ч байсан. Тэгэхээр энгийн зөвшөөрөл болгох бол асар чухал байгаа юм. Тэгэхээр төрийн энэ ийм хүнд суртал. Хүнд тусалж чаддаггүй юм гэхэд ядаж саад тотгор учруулмааргүй байна. Нэг их бүтээн байгуулаад гайхамшиг бүтээгээд байж бол чадахгүй юм байна. Гол нь ядаж оролцоогоо багасгах хэрэгтэй. Тийм учраас энийг энгийн зөвшөөрөл болгоно. Тэгээд Алдаржавхлан гишүүний хуулийг хэлэлцээд, тэгээд дэмжээд бид нар бас гол саналуудаа оруулаад явах нь бол зөв. Цаг үеэ олсон л бид нар хууль хэлэлцэж байна шүү дээ. Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууна.

**Б.Түвшин:** Та бүхэндээ өглөөний мэндийг хүргэе. Энэ хуулийн төслийн үзэл баримтлал болохлоороо усан сан бүхий газарт олборлолт явуулахгүй байна гээд тодорхойлсон. Харин хэрэгцээ шаардлага нь болохоороо нийслэлд ойр иргэдийн эрүүл орчинд төвлөрсөн. Тэгэхээр нэг ёсондоо зорилго болон хэрэгцээ шаардлага 2 зөрүүтэй тодорхойлогдсон. Тэгээд усан сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын буюу энэ хайрга дайргын олборлолт хийх зохицуулалт Усны хууль дээр бол байж байгаа. Нийслэлийн тухайд усны хамгаалалтын газар онцгой тохиолдолд 50 метр, ердийн тохиолдолд 200 метрт үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдол одоогоор байхгүй гэсэн ийм мэдээ ирсэн байж байгаа.

Харин одоогийн бид нарын санал болгоод байгаа хуулийн энэ санаа бол усны сан бүхий газраас 1км гэсэн зохицуулалт нь усны сангаасаа илүүтэй энэ суурьшлын бүсийн асуудлыг л яриад байх шиг байна л даа. Тэгэхээр энэ тохиолдолд ер нь бол 2, 3 асуудал гарч ирж байгаа юм. Нэгэнт зорилго нь суурьшлын бүс юм бол энэ суурьшлын бүсийн асуудлыг ер нь яг яаж шийдэх вэ. 1 км хангалттай юу, хангалтгүй юу. Дахиад энэ өөр үзэл баримтлалаар авч үзэх ёстой юм биш үү. Магадгүй нийслэлийн иргэдийн Хурлын төлөөлөгчдөд нь ч юм уу эрх шилжүүлдэг ч юм уу энийг зохицуулдаг ч юм уу. Нөгөө талдаа бол эрх зүйн орчны хувьд бол тэр олборлолт хийж байгаа газар, иргэдийн амьдарч байгаа бүс нутаг давхцалчих юм бол зохицуулалт хийх эрх зүйн зохицуулалт нь байж байгаа. Тэгээд ингээд харахаар яг зорилго, хэрэгцээ шаардлага 2 нь бол 2 өөр байгаад байгаа. Тэгээд энийг яаж зохицуулах вэ. Ер нь бол усны сав газар бүхий байгаа хуулийн зохицуулалт дээр нэмэх нь суурьшлын бүсийн асуудлыг зорилгоор нь тавиад тааруулчхаж байгаа юм

биш үү л гэсэн нэг ийм санаа байгаад байгаа. Тэгээд энэ дээр тодорхой хариулт авчихъя.

**Н.Учрал:** Алдаржавхлан гишүүн хариулъя.

**Ж.Алдаржавхлан:** Түвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Түвшин гишүүн ийм байгаа юм. Та жишээ нь 46 аж ахуйн нэгж огт үйл ажиллагаа явуулахгүй байна гээд хэлж байна шүү дээ. Туул голын орчимд. Тэд нар олборлоод дуусчихсан. Тэгээд иргэд гомдол гаргахаар тэр үндэслэл байхгүй болчихоод байгаа юм. Хортой нөхцөл тогтоогдохгүй байгаа юм. Тийм учраас энэ хуульд орон нутаг дээр байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатын Засаг дарга нар нь хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа талаарх гомдлыг үндэслээд, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх тухай хүсэлтийг Байгаль орчны яаманд гаргана л гэж байгаа байхгүй юу. Ийм заалт огт байхгүй. Тэгэхээр иргэн хаашаа хандах нь мэдэгдэхгүй болчихоод байгаа юм.

2 дугаарт суурьшлын бүс одоо хүртэл тогтоогдоогүй байна. Суурьшлын бүсийг тогтоохгүй бол 1 км чинь хаанаас хэмжих нь тодорхойгүй яваад байгаа. Тийм учраас энэ дагаж мөрдөх журмын тухай хуулиар нь 2026 оны эхний улиралд багтаагаад аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг дарга нар суурьшлын бүсээ тогтоо гэдэг заалтыг оруулж өгч байгаа юм. Тэгээд түүний дараа суурьшлын бүс тодорхой болох юм.

Тэгээд ерөөсөө та бас зөв хэлж байна. Ер нь хэдүүлээ бас ажлын хэсэг дээр сайн ярилцъя гэж бодож байгаа. Хамгийн гол үзэл санаа нь иргэний эрхийн асуудал байгаа. 1 км-ийн асуудлыг бас олон гишүүд бүтээн байгуулалт холбож ярьж байна лээ. Тэрийг бас эргэж харж ярилцах боломжтой юм байна гэж үзэж байгаа юм.

**Н.Учрал:** Тодруулъя. Түвшин гишүүн тодруулъя.

**Б.Түвшин:** Харин тийм ээ. Тэр усны газар олборлочихсон байгаа. Тэгээд олборлочихсон нөхцөлд тэр нөхөн сэргээлтийн асуудал эзэнгүй болчихож байгаа нь 1 дүгээр асуудал. Тэгэхээр энэ чинь усны сав газрын тухай олборлолтын асуудал 1 дүгээрт энд яригдахад бас арай өөр нөхцөлөөр яригдах гээд байна.

2 дугаарт яг энэ хуулийн үзэл санаа бол суурьшлын бүсээ тодорхойлох. Тэгээд суурьшлын бүсээ нэгэнт тодорхойлох юм бол 1 км нь өөрөө бас хангалттай юм уу, хангалтгүй юм уу. Суурьшлын бүсийн зохицуулалтын асуудал ингэж яригдах үндэслэлтэй болчихож байгаа учраас энэ хуулийн үзэл баримтлал дээр эсвэл суурьшлын бүсээ түлхүү ярьж байж энэ өөрөө бас яригдах болох юм байна гэдгийг л хэлэх гэсэн юм.

**Н.Учрал:** Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгаас Улаанбаатар хотод суралцдаг оюутан, залуучууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Оюутан, залуучууд та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.

Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар асуулт асууна.

**Г.Ганбаатар:** Өглөөний мэнд. Одоо Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг уг нь яг тухайн салбарынх нь яам, Байгаль орчны яам, тэгээд орон нутгийн удирдлагуудтай яваад нэлээн өргөн хүрээнд судалж орж ирсэн бол их зүгээр байсан юм болов уу гэсэн бодол байгаа. Ер нь бол зөвхөн байгаль орчин суурьшлын бүс энэ Улаанбаатар хотын Туул голын орчимтой л холбоотой л гол өөрчлөлтүүд оруулж ирж байгаа юм байна. Яах вэ, энэ хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судалсан судалгааны тайлангаа 2022 оны байдлаар гэж авсан байгаа юм. Тэгээд энэ барилгын салбарт 18518 аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 7217 нэгж үйл ажиллагаа явуулж байна гээд. Энэ яагаад 2024, 2025 оныхоор авч болоогүй юм бол. Яагаад 2022 оныхоор хийсэн юм бол энэ судалгааныхаа тайлангаа. Эдгээр аж ахуйн нэгжүүд чинь бүгд түгээмэл тархацтай ашигт малтмалын эрх авсан аж ахуйн нэгжүүд үү. Мөн хуулийн төслийн танилцуулгад Улаанбаатар хотын барилга, авто замын бүтээн байгуулалтад ашиглаж байгаа хайрга, дайргыг 100 хувь нийслэлийн нутаг дэвсгэрээс тодруулбал, Туул голын сав газраас хайргыг ихээр олборлож байна гэж. Тэгэхээр жилдээ яг хэчнээн куб хайрга, дайргыг зөвхөн энэ Туул голын орчмоос олборлодог юм. Яг энэ тоонууд байна уу. Энийг би яагаад асууж байгаа юм бэ гэхээр ер нь зөвхөн түгээмэл тархацтай зөвхөн Улаанбаатар орчмоор харах биш, энийг нэлээн өргөн хүрээтэй харсан бол орон нутагт ч, бид нарт ч бас хэрэгтэй байсан. Одоо энэ түгээмэл тархацтай гэдэг нэрийн чинь доор хөдөө бүр жонш хүртэл олборлодог болчихоод байгаа юм.

Дээрээс нь тэр түгээмэл тархацтай гэдэг нэрийн дээр жонш олборлож байгаа чинь хууль бус шүү дээ. Хууль бус ахиад тээвэр явж байгаа юм. Манай аймгийн прокурорууд 1 судалгаа хийсэн байсан. Прокурорын газраас. Тэгээд хууль бус тээвэрлэлттэй холбоотой. Ингээд ярих юм бол маш их асуудал байгаа байхгүй юу. Юу ч гэсэн миний түрүүний асуусан 3 асуултад хариулаад өгөөч. Тэрний дараа би ахиад тодруулъя гэж бодож байна.

**Н.Учрал:** Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Ганбаатар гишүүн юу яадаг шүү дээ. Хууль санаачлахад чинь Засгийн газраас бид нар мэдээлэл авдаг. Усны газар, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас бүгдээс нь мэдээлэл авахад тэндээс ирүүлж байгаа тоо баримт нь өөрөө 2022 оноор ирээд байгаа юм. Засгийн газар дээр байгаа тэр тайлан нь 2022 оноор байгаа юм байна лээ. Тийм учраас бид нарын хувьд энэ тоог үндэслэхээс өөр аргагүй болсон.

Яах вэ, хэчнээн куб/метр хайрга, дайрга олборлож байгааг манай нийслэлийн хэлтсийн дарга хариулж чадах уу, үгүй юу. Хариулт өгч болно. Бусад асуудлуудаар хэдүүлээ бас энэ хуулийн ажлын хэсгийг байгуулаад, зарим нэгэн заалт дээр бас хамтарч ажиллаж болно гэж бодож байна. Яагаад гэвэл энэ хуулийг би бас олон жил ярилцаж байгаад, иргэдийнхээ санал, хүсэлтийн дагуу боловсруулсан. Та хэд маань бас нэгдээд явсан бол анхнаасаа бас нэгдээд явах бололцоо байгаа. Тийм учраас иргэдийн цэвэр шаардлага, хүсэлтийн дагуу боловсруулагдсан хууль гэж ойлгож болно.

**Н.Учрал:** Баярлалаа. Намын бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүд урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр суурийг илэрхийлнэ.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Нэр өгсөн дарааллын дагуу үг хэлэх гишүүдийг индэрт урьж байна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн байхгүй байна. Мэндбаярын Мандхай гишүүнийг индэрт урья. 1 дүгээр микрофон. Дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлнэ.

**М.Мандхай:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр яах вэ, би бол аж ахуй эрхэлж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох хэрэгцээ шаардлага эдийн засгийн нөхцөл байдал үүсээд, ингээд бас суурьшмал газар, усны сан ойр газар зөвшөөрөл аваад, энэ хайрга, дайргын олборлолт эхлээд явж байгаа асуудлыг бол ойлгож байгаа.

Гэхдээ бид нэг зүйлийг ойлгох ёстой. Бидний хувьд бол урт хугацаанд энэ байгалийн баялаг, ялангуяа бидний хувьд баялаг болсон энэ усны сан бүхий газрыг урт хугацаанд ашиглаж, өөрийн гэсэн өөрсдөө устай худагтай, хөрс хамгаалалттай ийм орчинд амьдрах уу эсвэл хайрга дайрга усныхаа сан газар олборлоод, барилга байшингаа түлхүү олон хугацаанд олон жил явах уу гэдэг асуултын дунд л бид нар оршоод байна л даа. Тэгэхээр яг одоогийн нөхцөл байдалд иргэдийн ирж байгаа гомдол, саналыг хүлээж аваад, яг үндсэндээ бол энэ усны сан бүхий газар өөрөө жирийн газар биш юм гэдгийг бас бүгдээрээ хаана хаанаа бол ойлгох нь зүйтэй байх. Ер нь бол усны сан бүхий газар гэдэг нь өөрөө зөвхөн голын ус бол биш юм байгаа юм. Түүний эрэг, ёроол, хөрс, гүний ус, ургамал, ан амьтан, мөн доор урсах энэ суурьшлын бүсийг хамарсан энэ өөрөө эко систем юм гэдгийг бас ойлгох хэрэгтэй. Тэгэхээр энэ түгээмэл тархац, ялангуяа усны сан газар түгээмэл тархацтай ашигт малтмалыг бид нар олноор нь олборлосноор голын ёроол эвдэрч байгаа юм. Усны урсац бас өөрчлөгдөж байна, булингартаж байна. Үүнээсээ болоод гүний усны асуудал бас унадаг ийм түвшин үүсээд байгаа юм. Тийм учраас мэдээж энэ хуулийг бол өргөн цар хүрээнд сая гишүүдийн ярьсан асуудлаар бас ажлын хэсэг байгуулагдаад ажиллах хугацаандаа бас нэлээн өргөн цар хүрээнд нь бас авч үзээд, олон талын бас ашиг сонирхлыг тэнцвэртэй. Гэхдээ илүү бид нар, байгаль орчин, усны сан, газар үүсээд байгаа сөрөг нөлөөллийг аль болох бууруулахгүй талаас нь хандаж энэ хуулийг дэмжих нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгээд тийм учраас хэлэлцэх эсэх асуудлыг дэмжээд, тэгээд ажлын хэсэг гараад өшөө сайжруулаад явах боломжтой гэж харж байгаа.

**Н.Учрал:** Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд дэмжсэн байр сууриа илэрхийлнэ. 1 дүгээр микрофонд урьж байна.

**С.Эрдэнэболд:** Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Тэгээд түрүүн бас Идэрбат гишүүн, Батжаргал гишүүний хэлж байсантай бас санал давхцаж байгаа. Ерөнхийдөө бол яг усны ай сав газар, сан бүхий газар өнгөрсөн хугацаанд хэчнээн хэмжээний тусгай зөвшөөрөл гараад, тэр нь ямар бүс нутгуудад ямар тоон үзүүлэлттэй байгаад, энэ нь эргээд байгаль орчинд ямар хэмжээний хэрвээ мөнгөн хэлбэрээр тогтоогдвол хэчнээн хэмжээний төгрөгөөр үнэлэгдэх хохирол гарчхаад байгаа вэ гэдэг ийм судалгаануудыг маш сайн олон нийтэд гаргаж өгөх зайлшгүй шаардлагатай байгаад байгаа юм. Мэдээж энэ бол хуулийг санаачлах нийгэм, эдийн засгийн үндэслэл байгаа шүү дээ. Тийм ээ. Энийгээ бол маш сайн гаргаж өгөх хэрэгтэй.

Нөгөө талаасаа бас зүгээр ингээд усны сан бүхий газраас гадна ер нь бол жишээ татахад бид нар Дархан руу Дарханы замаар явахад зам зуур маш олон

ингээд хайрга дайрга аваад, тэрийгээ ухаад, дэлбэлээд дэлбэлээд хаячихсан юм шиг онгойсон онгойсон том ийм сүйтгэлүүдийг ингээд гаргачихсан. Энэ дээрээ эргээд ер нь яг ямар хариуцлага байх вэ. Тэгээд энэ хууль хэлэлцэж байгаатай холбогдуулаад Сонгинохайрхан дүүргийн иргэн Дуламжав гэдэг хүн надад нэг санал хэлсэн. Энийг хэлээд өгөөч гэсэн. Яг энэ Туул голын ай савд асар их хэмжээний бас барилгын хог хаясан байна гэж. Тэгээд яг энэ юуны баруун талын нөгөө сайжруулсан нүүрс савлаж үйлдвэрлэдэг байсан тэр газрын яг урд талын хэсэг дээр бол маш их хэмжээний голын ай саваас хайрга дайрга аваад, оронд нь барилгын хэдэн зуун тонн хог хаясан ийм фото зургууд явуулсан. Тэгээд энэ дээр Байгаль орчны яам болон энэ холбогдох хүмүүст нь дуулгаж өгөөч гэсний дагуу бас ингээд дуулгаж байгаа юм. Тэгэхээр ер нь бол энэ хууль гараад, гол нь мөрдөгдөх, хэрэгжих, энэ хуулийг ашиглаж амилуулах гэдэг бол маш чухал зүйл байгаад байдаг.

Бид нарт батлагдсан хууль бол хангалттай байгаа ч гэсэн түүнийг олон улсын хэллэгээр нь implementation буюу хэрэгжүүлэх, энийг хяналт тавих гэдэг бол маш чухал зүйл байгаад байдаг. Би төвийн бүсээс Дархан, Сэлэнгэ, Төв аймгаас сонгогдсон. Манай хойд талын аймгуудаас бол бас их саналууд ирдэг. Ямар саналууд ирдэг вэ гэхээрээ энэ их авлига, хээл хахуулийн бас нэг шалтгаант нөхцөл болоод байгаа юм биш шүү. Маш хүнд суртал дагуулаад байгаа юм биш үү. Одоо нөгөө төвлөрсөн ингээд өгөхөөр. Эсвэл бас 2 талтай. Нөгөө орон нутагт нь ингээд бүх эрх мэдлийг нь өгчихөөр тэнд бас тодорхой хэмжээний явцуу ашиг сонирхол үйлчлээд байгаа юм биш үү гэж. Тэгэхээр энэ аливаа нэгэн лицензийг өгөхдөө зөвхөн усны сан бүхий газраас гадна ер нь энэ ил тод байх, эргээд тэндээс тодорхой хэмжээний ашиглалт, олборлолт явууллаа гэхэд нөхөн сэргээх, эргээд тэр нь байгаль орчин, экологид хор хөнөөлгүй байх тал дээр нь хамгийн бага түвшинд хор хохиролтой байх тал дээр нь энэ хууль маань бас явах ёстой гэж үзэж байгаа. Тэгээд цаашлаад бол хэлэлцүүлгийн шатад тодорхой саналуудыг хэлээд явна гэж бодож байна.

Ер нь ингээд том зургаараа харах юм бол та бүхэн бас мэдэж байгаа. Манай Заамар. Зарим томоохон компани голын голдирлыг өөрчлөөд, Туул голын урсцыг нь өөрчлөөд, гол урсаж байсан газар нь хүртэл олборлолт хийгээд, ухаад төнхчихсэн зүйлүүд маш их гарсан. Одоо манай Тосон, Заамар гээд очиход бол нүд халтирам, түүндээ хүмүүс нь дасчихсан зүйлүүд ч гэсэн байгаад байгаа. Тэгээд түрүүн бас хэн гишүүн хэлэв дээ. Ер нь асуудлыг илүү их цогцоор нь, хооронд нь, хууль хоорондын уялдаатай авч үзэх талаас нь бол би саналаа хэлнэ. Ийм учраас Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт .../минут дуусав/

**Н.Учрал:** Олон нийтэд хуулийн талаар маш олон бас мэдээллүүдийг энэ хэлэлцүүлгийн явцад өгч байна. Тэгээд парламентын хэлэлцүүлэг бол иргэд олон нийтэд зөв мэдээлэл өгөхөд оршино. Тийм учраас Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн талаар бас иргэд, олон нийтэд мэдээллийг сайтар өглөө. Сандагийн Бямбацогт гишүүн байхгүй байна. Тэгэхээр одоо Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулсан тул хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалтыг явуулах ёстой. Одоо Байнгын хорооны саналаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн талаар санал хураалтыг явуулна. Дэмжсэн, дэмжээгүй урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд үг хэлж дууслаа. Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр мөн санал хураалтыг явуулах ёстой. Санал хураалтыг 3 асуудлаар нэгтгээд явуулъя.

11.24 цаг.

2 дугаар асуудалд оръё.

**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.**

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг танилцуулна. Таныг индэрт урья.

**Н.Алтанхуяг:** Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох заалт, 14.10 дугаар зүйлийн 11, 12 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай 07 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал 2025 оны 9 сарын 23, 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн билээ.

Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 13 дугаар тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох хэсэгт зохих өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ахлагчаар нь Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл, Отгонбаяр, Сайнзориг, Тэмүүжин, Уянгахишиг, Энхбаяр нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллалаа.

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 сарын 16-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул уг төслийг анхны хэлэлцүүлгээр эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 73,3 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 7 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Н.Алтанхуяг:** Алтанхуяг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ядамдоржийн Жавхлан, Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Батаагийн Батцэрэн, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх Максимын Чинбат, Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Батзэвэгийн Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн Цэрэнсүрэнгийн Лхагвацэнд гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн байхгүй байна. Байгаа юм байна. Тэгэхдээ нэрээ татаж байгаа юм байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн мөн нэрээ татаж байна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн бас нэрээ татаж байна. Хүрэлбаатарын Баасанжаргал бас нэрээ татаж байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Гишүүдээ санал хураалт явуулна. Тэгээд санал хураалтуудыг нэгтгээд явуулъя гэж шийдвэрлэсэн байгаа. Эхний асуудал мөн дараагийн асуудал 2, 3, 4 дүгээр асуудал хуулийг эцэслэн батлах асуудал. Мөн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн хуулийн эцэслэн батлахаар бас санал хураалтуудыг явуулахаар хэлэлцэх асуудал төлөвлөгдсөн байна. Гишүүдийг танхимд урья. Санал хураалтаа явуулах уу.

Оросын Холбооны Улсын болон Монгол Улсын Засгийн газар хоорондын комиссын хурал давхцаад, Засгийн газрын гишүүд тэр комиссын хурал байгаад байгаа юм. Тэгээд түүнтэй холбогдуулаад энд бас санал хураалт давхцаад байгаа юм.

11.30 цаг.

Улсын ерөнхий прокурорын орлогчийн асуудал чинь хэддүгээр асуудал байна. Тэгэхээр энэ чинь нөгөө хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулахаар санал хураалтыг хойшлуулаад явчихъя. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэх ёстой. Мөн хуулийн төслүүдийг эцэслэн батлах асуудлуудыг хэлэлцэх ёстой. Эдгээр асуудлуудыг хойшлуулаад, дараагийн асуудал буюу Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцье.

11.31 цаг.

Ерөнхийлөгчийн Тамгын газарт мэдэгдье.

**Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцье.**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Алтанхуягийн Үйлстөгөлдөрийг урьж байна. Ерөнхийлөгчийн Тамгын газарт мэдэгдье. 2, 3 дугаар асуудал нь түр хойшилсон тул Прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх асуудлыг хэлэлцэж эхэлье. Энэ асуудлын дараа санал хураалт явуулна. Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. Комиссын хурал дууссан уу. Хэрэг эрхлэх газар луу мэдэгдье. Нөгөө дараагийн 2 асуудал хойшилсон тул прокурорын оролцогчийг хэлэлцэх гэж байна. Ерөнхийлөгч Тамгын газарт мэдэгдье.

Зочид ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү Төрийн ордны үйл ажиллагаатай иргэдээ ингэж өөрөө танилцуулж, өөрөө тайлбарлаж, бас шинэ жишиг тогтоож байна.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Баатархүү гишүүнийхээ мэндчилгээг та бүхэнд хүргэе. Бас тойргийнхоо иргэд, сонгогчдодоо шинэ оны халуун мэндчилгээг дэвшүүлье. Эрүүл энх, сайн сайхныг хүсье. Батсүмбэрэл гишүүн бас мэндчилгээ дэвшүүлж байна.

Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Алтанхуягийн Үйлстөгөлдөр танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**А.Үйлстөгөлдөр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу Максимын Чинбатыг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох саналыг зөвшилцөхөөр танилцуулж байна.

Адуучин сүрэг овогтой Максимын Чинбат 1973 онд Сүхбаатар аймагт төрсөн, 52 настай, ам бүл 6, эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1981-1991 онд Сүхбаатар аймагт Ерөнхий боловсролын дунд сургууль, 1991-1995 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй. Төрийн хууль цаазын шадар зөвлөх зэрэг дэвтэй.

Чинбат 1995 оноос Сүхбаатар аймгийн Прокурорын газарт Хяналтын прокурор, Аймгийн прокурорын орлогч, аймгийн прокурор, 2007 оноос Багануур дүүргийн Прокурорын газарт туслах прокурор, Дүүргийн прокурорын орлогч, 2014 оноос Дүүргийн 1 дүгээр прокурорын газарт Тамгын хэлтсийн дарга, 2015 оноос Баянгол дүүргийн Прокурорын газарт Хяналтын прокурор, Тамгын хэлтсийн дарга, 2017 оноос Чингэлтэй дүүргийн Прокурорын газарт Ахлах прокурор, 2019 оны 2 дугаар сард Улсын ерөнхий прокурорын газарт Хяналтын прокурор, мөн оны 4 сараас Улсын ерөнхий прокурорын орлогчоор тус тус томилогдсон. Прокурорын байгууллагад прокуророор 30 дахь жилдээ ажиллаж байна.

Иймд Максимын Чинбатыг Монгол Улсын ерөнхий прокурорын орлогчоор томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэлэлцэн шийдвэрлэхийг хүсье. Баярлалаа.

**Н.Учрал:** Үйлстөгөлдөр даргад баярлалаа. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Номинчимэг гишүүн таныг индэрт урьж байна.

**О.Номинчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын

Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Максимын Чинбатыг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох асуудлыг зөвшилцөхөөр Монгол Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон нэр дэвшигчийн танилцуулгыг Байнгын хорооны хуралдаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Энхтүвшиний Золбоо танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг прокурорын ёс зүйн асуудлыг шийдвэрлэж байгаа тогтолцооны талаар, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд прокурорын оролцоог цахимжуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаар, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотойгоор прокурорын шатад хэрэгсэхгүй болсон болон мөрдөн байцаалтад буцаасан хэргийн талаар, 2025 оны байдлаар төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой прокурор дээр хянагдаж байгаа болон илрүүлсэн хэргийн тоон мэдээллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Прокурорын дэргэдэх мөрдөн шалгах албаны талаар, хүний эрхийн төлөв байдлыг сайжруулах хүрээнд хууль хүчний байгууллага тэр тусмаа прокурорын байгууллагын оролцоог хэрхэн хангах талаар, улираан томилогдох болсон үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Прокурорын байгууллагын хувьд цаашид анхаарч засах, сайжруулах ажлын талаар, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурорын хараат бус байдлыг хангах хүрээнд хууль тогтоомжийн болон дотоод зохион байгуулалтын хувьд авах арга хэмжээний талаар, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Улсын ерөнхий прокурорын мэдээллийг Улсын Их Хуралд ирүүлээд зогсохгүй, Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцдэг байх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал эрүүгийн процессын ажиллагаанд прокурорын хяналтад байгаа зарим ажиллагааг шүүхийн хяналтад шилжүүлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, эд хөрөнгө хураах, битүүмжлэх талаар прокуророос хэрэгжүүлсэн ажлын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Максимын Чинбатыг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох асуудлыг зөвшилцөхөөр ирүүлсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 80 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшилцөх саналыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Н.Учрал:** Номинчимэг гишүүнд баярлалаа. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Их Хурлын гишүүд нэрээ өгье. Нэр дэвшигч Максимын

Чинбат хүрэлцэн ирсэн байна. Золжаргал, Мөнхбаясгалан гишүүнээр тасаллаа. Ирцээр нь эрэмбэлье. Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасалж байгаа юм байна. Ирцээр эрэмбэлсэн Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

**С.Эрдэнэбат:** Нэр дэвшигчээс 1 зүйлийг асууя гэж бодож байна. Прокурорын байгууллагуудын хэрэг, хэргийн архив хэр зэрэг цахимжсан байдаг вэ. Зарим асуудлаар 1 хэргийн асуудлаар 3, 4 удаа одоо бас энэ мөрдөх зарим байгууллагууд бол хэрэг үүсгэж, дахин дахин 10, 20 жилийн өмнөх ч асуудлыг шалгадаг. Энэ нь эргээд өөрөө бас тодорхой архив, материал юм байдаг бол энэ хэргийг хүлээж авах, хянах, хэрэг нээх энэ үйл ажиллагаануудад дата бааз дээрээ хэр зэрэг анализ хийдэг юм. Прокурорын байгууллагууд энэ тал дээр хэр зэрэг бэхэжсэн байдаг юм. Магадгүй зарим тохиолдолд ийм мэдээллээ хоорондоо солилцдоггүй, тус тусдаа цахимжуулаагүйгээс шалтгаалаад иргэдийг чирэгдүүлэх, тэгээд мөн тодорхой хэрэгтэй холбогдуулан шалгагдаж байгаа, ингэж байгаа гэдэг нь бол эргээд бас нийгэмд тухайн хүний нэр хүнд, мөн ажил төрөл, тухайн байгууллага гээд олон хүмүүс бас хохирох тохиолдлууд байдаг. Тэгээд энэ тал дээр бас тодруулж асууя гэж бодож байна.

**Н.Учрал:** Нэр дэвшигч Максимын Чинбат 4 дүгээр микрофонд хариулна.

**М.Чинбат:** Гишүүний асуултад хариулъя. Прокурорын байгууллага 2022 онд анх удаагаа дунд хугацааны бодлогын баримт бичиг болох стратеги төлөвлөгөөг 2026 он хүртэл хэрэгжүүлэхээр анх удаа баталсан. Энэ стратеги төлөвлөгөөнд бол 5 зорилт тавигдсаны 1 нь бол цахимжуулалтын асуудал орсон. Цахимжуулах асуудал бол прокурорын байгууллагын эн тэргүүний асуудал. Ялангуяа энэ дээр эрүүгийн хэргийг цахимжуулах асуудал нэлээд бодлогын шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бол 2023 оноос эхлээд Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар тодорхой төсөл хөтөлбөр хэрэгжээд, 2026 оноос эхлээд зөрчил шийдвэрлэх ажиллагаа бол цахимаар явагдахаар болсон. Эрүүгийн хэргийг бол цахимжуулах асуудалд бид судалгааны түвшинд, бодлогын түвшинд, гаднын улс орнуудын байгууллагуудтай хамтарч турших, судлах, энэ чиглэлээр 2026 оноос эхэлж тодорхой ажил, арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрээр явуулж болох хуулийн зохицуулалтыг бол Улсын Их Хурлаас 2023 онд тусгаж өгсөн. Тэгэхээр хууль, эрх зүйн хувьд бол хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах ийм бүрэн боломжтой байгаа юм.

**Н.Учрал:** Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууна.

**О.Алтангэрэл:** Өнөөдөр сая энэ хэлэлцэх асуудлын өмнө танилцуулсан Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн процессын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал манай Норовын Алтанхуяг гишүүнээр ахлуулаад, ажлын хэсэг гараад ажилласан. Тэгээд эхний хэлэлцүүлгээр нь батлах санал гаргасан. Тэгээд энэ хуулийн өөрчлөлтийг өнөөдөр гишүүд маань бас нэлээн хариуцлагатай байж батлахгүй бол ямар байдал үүсээд байгаа вэ гэхээр өнөөдөр шүүх дээр хянагдаж байгаа хэргүүд цаашаагаа энэ чинь янз янзын хэрэгт холбогдсон хүмүүс байгаа. Онц ноцтой гэмт хэргүүдэд холбогдсон хүмүүс ч байгаа, авлига, албан тушаал, хүн амины хэрэгт холбогдсон хүмүүс ч байгаа. Эдгээр шүүх дээр хянагдаж байгаа хэргийн хүмүүсийг цагдан хорихтой холбоотой асуудал энэ

оноос өмнө батлахгүй бол энэ бүх хүмүүс суллагдах, шүүх хэрэглэх хуульгүй болох ийм аюул нүүрлээд байгаа юм шүү. Тэгээд үүний дараа явах санал хураалтад манай гишүүд бас хариуцлагатай оролцож, энэ хуулийн төслийг батлах дээр нь бас оролцоно уу гэж хүсье.

Чинбат прокурорын хувьд бол ер нь өмгөөллийн чиглэлээр явж байсан, шүүн таслах ажиллагаагаар явж байсан хуульчид бол сайн мэднэ дээ. Манай энэ прокурорын байгууллагын бас олон жил ажиллаж байгаа бас эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр ч бай, Улсын Их Хурал, бусад газруудаас байгуулагдсан хуулийн ажлын хэсгүүдээр ч бай дуу хоолойгоо гаргаж явдаг нэлээн хариуцлагатай ажилладаг ийм хүн байгаа юм. Тийм учраас прокурорын орлогчоор үргэлжлүүлэн ажиллахад ямарваа нэг саад бэрхшээл, эргэлзэх зүйл байхгүй гэж бодож байна. Тэгэхдээ 1 асуулт байгаа.

Энэ төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах гэж прокурорын байгууллагад 1 чухал чиг үүрэг байгаа. Энэ төрд хохирол учруулсан этгээдүүдийг төрийн нэрийн өмнөөс нэхэмжилдэг, хохиролгүй болгодог энэ чиг үүрэг прокурорын байгууллагад бий. Тэгээд миний ойлгож байгаагаар Чимэд прокурорын өөрийн хариуцдаг ажлын хүрээнд энэ ажил байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд одоогийн явц, ер нь цаашдаа энэ чиглэлээр ямар ажил хийж, хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна вэ. Ямар ахиц дэвшил гаргах вэ гэсэн ийм асуулт байна.

**Н.Учрал:** Максимын Чинбат нэр дэвшигч хариулна.

**М.Чинбат:** Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Улсын Их Хурал, Засгийн газраас хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр ажлын хэсгүүд, дэд хэсгүүдэд Прокурорын байгууллагыг төлөөлж сүүлийн 6 жил оролцлоо. Энэ чиглэлээр хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиглэлээр, ялангуяа цагдан хорих, баривчлах, албадан саатуулах, хавтаст хэргийн материалыг оролцогчид танилцуулах чиглэлээр зарчмын шинжтэй гол гол асуудлууд дээр бас Прокурорын байгууллагын саналыг бас Их Хуралд тавьж, Засгийн газраас энэ төсөл хэрэгжүүлж ингэж явж ирсэн байгаа юм. Төр, нийтийн эрх ашгийг хамгаалах энэ чиглэлээр бол 2019 онд Прокурорын байгууллага тусгай ийм албыг бас бүтцийнхээ нэгж болгож ингэж байгуулж ажиллуулсан. 2022 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд прокурор төр, нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр, ялангуяа нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр прокурор төрийн байгууллагын хүсэлтээр мөн өөрийнхөө санаачилгаар оролцох энэ оролцоог бол хууль тогтоомжид тусгуулж, эрх зүйн орчноо бас нэлээн сайн бүрдүүлж чадсан гэж үздэг. Энэ чиглэлээрх ажлын үзүүлэлтүүд ч гэсэн бидэнд бас нэлээн өндөр харагдаж байна. 2019 онд төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр прокурорын байгууллага 90 нэхэмжлэл бичиж байсан бол 2024 оны дүн мэдээгээр бол энэ нь 1335 болж 31 дахин нэмэгдсэн. Түүнчлэн 2025 оны эхний 3 дугаар улирлын байдлаар бол бидний прокурорын нэхэмжлэл бичих асуудал бол 992 болж, өмнөх оныхоо мөн үеэс бас өссөн дүнтэй байгаа. Мөн төр, нийтийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэл гаргуулах, нэхэмжлэл өөрсдөө бичих, гуравдагч этгээдээр оролцох энэ оролцооны хувьд бол прокурорын байгууллага нэлээн өндөр дүнтэй, ажлын эерэг үзүүлэлттэй ингэж явж байгаа. Цаашид бол бид төр, нийтийн эрх ашиг хамгаалах чиглэлийнхээ энэ бүтцийг ч гэсэн бид нар дахин авч үзэж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийтийн эрх ашиг хамгаалах чиглэлээр тусгайлсан бүтэцтэйгээр энэ үйл ажиллагааг явуулахаар бодлогын хэмжээнд авч үзэж ингэж ажиллаж байгаа.

**Н.Учрал:** Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Мэдээлэл холбооны сүлжээ компанийн Сэлэнгэ аймгийн газрын ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Харилцаа холбооны салбарын ажилтан, албан хаагч та бүхэнд ажлын өндөр амжилтыг хүсье.

Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууна.

**Ж.Золжаргал:** Бид чөлөөт нийгэмд амьдарч байгаа. Хүн үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх нь эрх чөлөөтэй, Үндсэн хуулийн баталгаатай. Тэр нь зөв хэрэг. Биетээр болон нийгмийн сүлжээнд. Гэхдээ хүнийг, Улсын Их Хурлын гишүүнийг нэр овгийг нь ашиглаад, баталгаажсан цэнхэр тэмдэгт ашиглаад, үүсгээд өөрийнх нь ярьж хэлдгийн эсрэг зүйл тараадаг, маш бүдүүлэг бөгөөд онцгой хортой ийм үзэгдлүүд бол байна. Тэгээд 1 Дорж гишүүн, Бат гишүүн тэр хүн тийм улс төрийн яриа аваад хэдэн төгрөг авчээ гээд хаа хамаагүй аккаунтаас ингээд нийтэлчихдэг. Энэ асуудлыг шийдээч ээ гээд Цагдаагийн газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст хандаад, ингээд явахаар үзэл бодлоо илэрхийллээ гээд байдаг юм байна лээ. Үзэл бодлоо илэрхийлэх гэдэг бол Үндсэн хуулийн заалт. Хүн үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Харин Болдын нэрийг өөрийг нь бичиж байгаад, тэгээд нэр дээр нь ингээд Батын аккаунт гэдэг хуурмаг, цэнхэр тэмдэгт үүсгээд, тэгээд шал өөр юм тааруулдаг энэ бол гэмт хэрэг гэдэг нь илэрхий. Тэгэхээр энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ гэдгийг нэр дэвшигчээс асууя. Энэ бол зүгээр нэг ийм нийгмийн сүлжээ дэх сахилгагүйтэл биш байна. Улсын Их Хурал гэдэг бол Монголын хууль тогтоодог, хуулийн хэрэгжилтийг хангуулах, хянах үүрэгтэй байгууллага. Иргэдийн төлөөлөл болж орж сууж байгаа юм. Энд орж ирсэн хүнийг юм ярихаар нь тэнд хиймэл аккаунт үүсгээд, нэр хүндийг нь гутаадаг. Энэ бол Монголын төрийг үйл ажиллагааг сулруулах үр дагавартай. Зориг зүрх гаргаад явж байгаа, Улсын Их Хуралд ороод явж байгаа залуучуудыг мохоох зорилготой ийм хөгийн новшийн ажиллагаанууд бол тасралтгүй явагдаж байна. Энэ дээр хариулт өгөхийг хүсье.

**Н.Учрал:** Нэр дэвшигч Максимын Чинбат хариулна.

**М.Чинбат:** Гишүүний асуултад хариулъя. Хүний нэр төр бол Үндсэн хуулиар хамгаалагдсан. Төр хуулиар хамгаалахаас бусад асуудлыг бол хуулиар зохицуулна гэж ингэж тунхагласан байдаг. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг 2020 оноос хойш сая энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарах хүртэл эрүүгийн гэмт хэрэгт тооцож шалгадаг байсан. 2017 оноос бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар ингэж зохицуулж ирсэн. Тэгэхээр энэ бол яг хууль тогтоогчоос Эрүүгийн хуульд хэрхэн яаж тусгахаас шалтгаалж байгаа юм. Асуудал, хүний нэр төрийн асуудал зохицуулагдана гэж ойлгож байна. Одоо бол мөрдөн шалгах ажиллагаа бол Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хуулийн үйлчлэл түдгэлзсэн байгаа.

**Н.Учрал:** Золжаргал гишүүн тодруулна.

**Ж.Золжаргал:** Эрүүгийн хуулийн 13.14 худал мэдээлэл тараах гэдэг зүйл 2 талтай. Нэг талдаа энэ худал мэдээлэл байгаа тарааж байгаа хүнийг Эрүүгийн хуулиар шийтгэхээр шударга боловч, нөгөө талдаа сэтгүүлчдийг мохоох ажиллагаанд хэрэглэдэг. Юм төгс байхгүй учраас балансалж дэнсэлж үзээд, Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлт нь зөв юм байна гэж би хувьдаа дэмжиж байгаа. Харин хүний нэрийг тэрний тэр Жаргалсайханы Золжаргал гэдэг нэрийг нь ашиглаж, аккаунт үүсгээд, тэр дээрээ олон улсын нийтийн сүлжээн дээр баталгаажуулалтын тэмдэг аваад, өөрийнх нь ярьж байгаагийн эсрэг явуулж байгаа үйл ажиллагаа бол

ер нь сайн ярих юм бол төрийн эсрэг гэмт хэрэг шүү. Энэ дээр онцгой анхаарахыг хүсье.

Тэгээд ийм асуудлыг бол зүгээр хийгээд байгаа хүмүүст хэлэхэд техникийн аргаар энийг хаачихад ямар ч хүндрэл байхгүй. Энэ платформууд чинь Монголынх ч биш, хаалгаад блоклож болно. Гэхдээ эрх чөлөөг хүндэтгээд байгаа учраас харилцан хүндэтгэн хандах /минут дуусав/

**Н.Учрал:** Санал хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн. Гишүүд танхимд орж ирье. Үүний дараа санал хураалт эхэллээ

**Л.Соронзонболд:** Чинбат прокурорыг дэмжиж байна. 1 асуулт байгаа юм. Сүүлийн үед цахим гэмт хэрэг бол маш их нэмэгдэж байгаа статистик үзүүлэлт байна. Энд манай өсвөр насны хүүхэд, залуучууд бас их хамрагдаж байна. Яг цаад талынх нь тэр технологи, процесс нь их нарийн байгаад байдаг. Энэ гэмт хэрэг нь өөрөө 12 сар хорьж байгаад байцааж шалгадаг ийм эрүүгийн хэрэг юм шиг байгаа юм. Тэгээд энэ дээр болохоор асуулт асуумаар байгаад байгаа нь юу вэ гэхээр энэ прокурор, хуулийн байгууллагын ажиллагсдад цахим гэмт хэргийн яг энэ цаад талын энэ технологи, процесс нь яаж явагддаг, яг хамгийн гол зохион байгуулагч нь яаж илрүүлэх юм. Наад талд нь зүгээр ингээд туслах байдлаар оролцож байгаа хүмүүс нь ямар байх юм гээд энийг ялгаж, салгах талаар нь нэлээн тийм сургалт, ажиллагсдынхаа мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх талаар ер нь прокурорын байгууллага маань ямар ажил хийж байна вэ гэж асуумаар байна.

Яагаад ингэж асууж байна вэ гэхээр сүүлийн үед хүүхэд, залуучууд энэ цахим гэмт хэрэгт ингээд холбогдоод, тэрэнтэй холбоотойгоор бас хорьж байцаагдаж байгаа ийм асуудлаар гомдол тавьж байгаа иргэд бас нэлээн байгаад байгаа юм. Тэгэхээр энэ талаар тодруулж асууя.

**Н.Учрал:** Нэр дэвшигч Максимын Чинбат.

**М.Чинбат:** Гишүүний асуултад хариулъя. Нийгэмд бол цахимжилт нэлээн өндөр ш хэмжээнд явагдаж байна. Монгол Улсын хэмжээнд. Энэ нь бол нэг талдаа эерэг тал нь илүү ч, бас сөрөг бас нөлөөлөл их байна. Эрүүгийн гэмт хэргийг бас цахим хэрэгсэл ашиглаж үйлдэх явдал бол сүүлийн 3 жилийн байдлаар нэлээн өндөр үзүүлэлттэй, өсөлттэй, ялангуяа залилах гэмт хэргийг цахим хэрэгсэл ашиглаж үйлдэх явдал бол өндөр байж байгаа. Үүнтэй бид тэмцэхийн тулд прокуроруудыг, мөрдөгчдийг чадавхжуулах ажлыг бол байнга зохион явуулж байгаа. Үүний дотор бол бид Ханнс-Зайделын сантай хамтарч ХБНГУ-ын мэргэжлийн эрдэмтэн, багш нарыг урьж, 2025 оны 4 сард, 6 сард Монгол Улсын мөрдөгч, прокуроруудыг чадавхжуулах талаар бол нэлээн онолын болоод практикийн сургалтыг бол зохион явуулж байгаа. Мөн энэ чиглэлээр сургагч багш бэлтгэж, практикт олон хүнийг хамруулах, олон мөрдөгчийг хамруулах чиглэлээр сургагч багшаараа дамжуулж, кибер гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр кибер гэмт хэрэгт үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах ажиллагааныхаа чиглэлээр, ялангуяа тэр технологийнх нь талаас бас шалгах аргачлалыг нь зөв болгох талаар нэлээд сургалт, хэлэлцүүлэг зохион явуулж байгаа.

**Н.Учрал:** Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн байхгүй байна. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Би асуулт байхгүй. Үг хэлье. Монгол Улсын ерөнхий прокурор томилогдох үед прокурорын хяналт, Прокурорын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хамтарч ажиллах саналыг хэлсэн. Энийг бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын ерөнхий прокурор бол хүлээж авсанд баярлалаа. Энэ чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд хамгийн их асуудал байж болзошгүй байгаа энэ мөрдөн шалгах ажиллагаа, гүйцэтгэх ажил, түүнд тавих прокурорын хяналт, прокурорын дотоод томилгоо, хэрэг хяналттай холбоотой үүсгэдэг, хаадаг энэ чиглэлийн асуудлыг их боловсронгуй болгох бодлого Хууль зүй, дотоод хэргийн сайдын эн тэргүүний бодлогод байгаа. Шүүхийн хуулийг бид шинэчилсэн. Одоо энэ дээр прокурорын асуудал үлдчихээд байгаа юм.

Зарим сайн зүйлээ бас хэлмээр байх юм. Тухайлбал яах вэ гишүүд ер нь асууж байна. Маш их ийм цагдан хориод байгаа юм шиг 1 мэдээлэл байгаа юм. Энэ бол багасаад байгаа шүү дээ. Жишээлбэл, 2023 оны 11 сард миний бие Хууль зүйн сайдаар томилогдоод, Улсын Их Хурал дээр энэ цагдан хорио, ялангуяа хөнгөн гэмт хэрэг дээр цагдан хоригддогийг болиулчихсан юм шүү дээ. Хорих ял эдэлж байгаа хэргүүд дээр цагдан хорих үндэслэлийг бас мөн нэн тодорхой болгочихсон. Ажлын хэсэг дээр бол прокурорын байгууллагаас өгсөн мэдээллээр 2023 оны 11 сард баталсан, бидний хамтдаа баталсан хуулийн үр дүнд сүүлийн 1 жил гаруй хугацаанд цагдан хорио 3 дахин буурсан гэсэн статистиктай байгаа шүү дээ. Тэгээд энэ чинь маш сайн үзүүлэлт ярьж байгаа байхгүй юу. Бидэнд бас ололт байгаа. Тэрнээс бүгдийг нь хорьж мөрдөөд байгаа гэсэн юм байхгүй.

Харин улс төрчидтэй ойр хүмүүс харин цагдан хорихоос зайлсхийж байгаа асуудлууд бол харин байна. Жишээлбэл, Амарбаясгалан даргын хэрэгт холбогдоод байгаа Эрдэнэжаргал гэж этгээдийг 2 удаа шүүгч дандаа шөнө оройн цагаар суллалаа. Уржигдар сулласан байна шүү дээ энэ шүүхийнхэн. Тэгээд мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулаад байгаа байхгүй юу. Гол хэргийн холбоотнуудыг. Өөрөө одоо Монголд байна уу, үгүй юу манай Амарбаясгалан дарга. Хилээр гараад явчихсан уу. Тэгээд энэ дээр жоохон шийдэмгий баймаар байх юм. Хууль зүйн сайд хэрэг маргаан шийдвэрлэдэггүй учраас бас нөлөөлчхөж болохгүй. Оролцдоггүй болохоор. Тэгээд бүрэн эрхийнх нь асуудлыг ер нь оруулж ирвэл яасан юм. Юунаас нь айгаад байгаа юм. Түдгэлзүүлээд шалгая л даа. Саад болоод байгаа бол /минут дуусав/

**Н.Учрал:** Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Үргэлжлээд санал хураалт явуулна. Гишүүд танхим цуглая. Тэр Засгийн газрын комиссын хурал дууссан уу. Батцэцэг сайд. Дуусаагүй юу. Харин энэ Орос, Монголын Засгийн газрын комиссын хурал болоод сайд нар тэр комиссын хуралд суугаад давхцаад байна.

Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэгийн урилгаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Төрийн өмчит компанийн Улаанбаатар салбарын инженер, диспетчерүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Инженерүүд, диспетчерүүд та бүхэнд ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье.

Санал хураалтуудыг явууллаа. Гишүүд танхим цуглая. Үргэлжлээд Хянан шалгах түр хорооны асуудлыг хэлэлцэх ёстой. Өчигдөр шөнийн 1:30-д түр хорооны хурал дууссан. Тэгээд өглөө материал тараасан, танилцаж дуусаагүй байна гээд маш олон шаардлагуудыг бас тавиад байна шүү дээ. Тэгээд түр хорооныхон ямар байр суурьтай байгаа юм. 1 сарын 2-нд түр хорооны хугацаа дуусах ёстой. Бас

харьцангуй хугацаа байгаа. Ирэх 7 хоногт хэлэлцэх ч хугацаа байгаа. Тэгэхээр нөгөөх өмнө нь Оюутолгойн Хянан шалгах түр хороог байгуулж ажиллаж байсан Даваасүрэн гишүүн байна. Сая Аюулгүй байдлын байнгын хорооны дарга Тэмүүлэн гишүүн гээд гишүүд байр сууриа илэрхийлээд л байна. Тэгэхээр гишүүдийн байр сууриудыг бол мэдээж сонсох ёстой. Гэхдээ түр хороо бие дааж, хараат бусаар үйл ажиллагаа явуулах ёстой. Бүх саналуудыг мэдээж тусгах албатай биш. Гэхдээ Их Хурлаар хэлэлцэх асуудал учраас Их Хурлын гишүүний хувиар хэн ч, ямар ч саналаа илэрхийлж болно шүү дээ. Байнгын хорооны эрхлэх асуудлыг Түр хороо хариуцна гээд энэ Хянан шалгах хууль, Их Хурлын хууль дээр биччихсэн. Ерөөсөө Байнгын хороогоор хэлэлцэхгүй түр хороо дэг нь тийм юм байна лээ. Түр хороо асуудлаа шууд Их Хуралд оруулдаг. Тамгын газар тайлбар хэлээрэй.

Санал, дүгнэлтийг бол Их Хурлын нэгдсэн чуулган дээр түр хороо танилцуулах эрх нь бол нээлттэй. Одоо сонсголтой холбогдуулаад санал, дүгнэлтээ танилцуулна. Гэхдээ түр хорооноос Их Хурлын тогтоолын төслийг өөрсдөө санаачлаад, өчигдөр олонхоороо санал хураагаад шийдсэн гэж би ойлгосон шүү дээ. Тэгээд өнөөдөр даргын зөвлөл дээр санал хураагаад, энэ тогтоолыг нэмэлтээр оруулъя гээд олонх нь дэмжээд, өнөөдөр Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах ийм хүсэлтээ түр хорооны дарга бас илэрхийлсэн. Тийм биз. Батнайрамдал гишүүн ээ, та нар сонсголтой холбогдуулаад тайлан, санал, дүгнэлтээ бол Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах эрхтэй. Гэхдээ түр хороо хэрвээ тогтоолын төсөл санаачилсан бол тус тогтоолын төслийг холбогдох Байнгын хороогоор хэлэлцэж, Их Хурлын чуулганд оруулж ирэх ийм дэгтэй гэдэг тайлбартай. Энэ дээр Тамгын газар тайлбар бэлдчихье.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Сайнбуянгийн Амарсайхан нарын урилгаар Налайх дүүргийн Ерөнхий боловсролын 103 дугаар сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.

Одоо санал хураана.

**Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжих санал хураалтыг явуулна.**

Гишүүд танхимд цуглая. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд танхимд цуглая. Санал хураана. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт.

Одоо байнгын хорооны саналаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Үзэл баримтлалын хүрээнд хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Санал хураалт. Гишүүдийн 47 дэмжиж, 51,1 хувиар санал дэмжигдлээ.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын

хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 50 гишүүн дэмжиж, 54,3 хувиар санал дэмжигдлээ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

12.06 цаг.

Дараагийн санал хураалтыг явуулъя.

**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг явуулна.**

Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Эхлээд нөгөө анхны хэлэлцүүлгээр баталъя гэсэн горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулах ёстой. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

1.Байнгын хорооноос Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт. 57 гишүүн дэмжиж, 62 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

12.07 цаг.

**Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох саналыг зөвшилцөх тухай асуудал.**

Гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Улсын ерөнхий прокурорын орлогчоор Максимын Чинбатыг томилох асуудлыг зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт. 65 гишүүн дэмжиж, 70,7 хувиар санал дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр явагдсан тус санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид Улсын Их Хурлын зүгээс албан бичгээр хүргүүлнэ. Баярлалаа. Максимын Чинбат танд баярлалаа. Ажлын амжилт хүсье. Мөнхбаясгалан гишүүнийг дэмжсэнээр бүртгэе.

12.09 цаг.

**Нийтээр тэмдэглэх баярын хууль дээр эцсийн хэлэлцүүлгийг хийх ёстой.**

Эцэслэн батлах ёстой. Санал хураана. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Санал хураалт явуулна.

1.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Хуулийн хүрээнд бол нийгэм, олон нийтэд зөв ойлголт өгөхөд зөвхөн Цагаан сар, Үндэсний Их баяр наадмын үеэр хэрвээ амралтын өдөр /Бямба, Ням/-тай давхацвал түүн дээр сунгаж болох л зохицуулалт байгаа. Тэрнээс биш бусад нийтээр тэмдэглэх баярууд огт хамаарахгүй. Зөвхөн Цагаан сар, наадмын үеэр амралтын өдөр давхацвал өдрийг нь хойшлуулж, амралтыг нь сунгах асуудал болохоос биш бусад баярын өдөр огт хамаагүй гэдгийг бас олон нийтэд зөв тайлбарлах нь зөв байна.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор ... энэ чинь заавал бэлдэх ёстой юм уу. Санал хураалтад бэлтгэе. Бүртгэлийн санал хураалт явах уу. Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль. Яах вэ, Засгийн газраас нийтээр тэмдэглэх баярын хууль дээр яг энэ Цагаан сар, наадам 2-ыг зохицуулалт хийгээч гэдэг ийм хуулийн төслийг боловсруулж барьсан. Одоо бол Батнайрамдал, Уянга гишүүн нарын санаачилсан хууль. Яг энэ Засгийн хуулийн концепцтой ижилхэн батлагдах гэж байна шүү дээ одоо. Яг адилхан болж байгаа гэсэн үг. Санал хураалт явуулъя. Санал хураалт явууллаа шүү. Уянга гишүүнээ явуулчих уу санал хураалтаа. Одоо бүртгэлийн санал хураалт.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг ... энэ Ардын намын бүлгийнхэн ... хураана шүү дээ. Эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Ардын намын бүлгийнхэн өөрсдөө ирцээ бүрдүүл. Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т зааснаар хуулийн төслийг эцэслэн батлах саналыг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжээгүй бол түүнийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоолыг баталсанд тооцно. Хуулийн дагуу хууль санаачлагчид хуулийн төслийг буцаалаа.

Өөрсдөө хууль оруулж ирээд, батлуулмаар байвал өөрсдөө ирцээ бүрдүүл. Хариуцлага ярих гэж байгаа бол өөрсдөөсөө хариуцлагаа нэх. Тийм биз дээ. Одоо тэгж бие биеэ гуйж ажиллахгүй шүү. Саяын санал хураалтыг 47 гишүүн буюу 51,1 хувиар зөвшөөрсөн.

12.15 цаг.

Дараагийн асуудалд орно.

**Хянан шалгах түр хорооны сонголын тайлан, санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Хянан шалгах түр хорооны тайлан болон санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны дарга Отгоншарын Батнайрамдал танилцуулна. Батнайрамдал гишүүнийг индэрт урьж байна.

**О.Батнайрамдал:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 126 гишүүний 89 гишүүн дэмжиж, санал гаргаснаар Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолоор Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулсан Оюутолгойн бүлэг ордын талбайн хил заагт орших Жавхлант, Шивээ толгой ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг ашиглахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэх, тэдгээрийн шаардлагыг хангуулах, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч талтай 2011 онд байгуулсан хувь нийлүүлэгчдийн гэрээ, нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосны 11.3.ё-д зааснаар хөрвүүлэх өдрөөс хойш 7 жил тутамд санхүүжилтийн хүүгийн зохистой хувийг хянан үзэх хугацаа 2025 онд болж байгаатай холбогдуулан Оюутолгой төслөөс хүртэх Монголын талын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2025 оны 7 сарын 2-ны өдрийн 62 дугаар тогтоолоор Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх хянан шалгах түр хороог байгуулсан билээ.

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн, Батнайрамдал, Бат-Эрдэнэ, Баярбаатар, Болормаа, Бямбасүрэн, Ганзориг, Жаргалан, Зулпхар, Пүрэвдаваа, Шижир нарын 11 гишүүн Монгол Улсын Их Хурлын тогтоолд заасан сэдэв, хүрээ хязгаарын дагуу хуулийн хугацаанд ажиллалаа.

Хянан шалгах түр хорооны 2025 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэгт заасныг баримтлан түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн миний бие Отгоншарын Батнайрамдалыг томилсон болно.

Энэ хугацаанд Хянан шалгах түр хороо 13 хуралдаж, 25 тогтоолыг баталж, нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг 2025 оны 12 дугаар сарын 8, 10, 12-ны өдрүүдэд зохион байгуулан нийт 300 орчим гэрч дуудагдсанаас 207 буюу 70 хувь нь хүрэлцэн ирж оролцлоо.

Парламентын түүхэнд 6 дахь хянан шалгах түр хорооны сонсгол болсон. Хамгийн өндөр ирцтэй бас сонсгол болж өнгөрсөн байгаа. Сонсгол нийт 35 цаг орчим үргэлжилж, 12 асуудлаар нотлох баримтыг шинжлэн судалж, олон нийтэд МҮОНРТ, Ийгл Тв, Монгол Тв, Блүүмберг, Монцамэ, NTV, TV9, SBN зэрэг телевизүүдээр шууд дамжуулж, хэвлэл мэдээллийн 40 орчим байгууллага ажиллаж, мэдээ сурвалжилга хийсэн байна.

Мөн холбогдох төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээд, Рио Тинто, Оюутолгой, Онтре компаниуд, иргэд, төрийн бус байгууллагуудын төлөөлөл бүхий нийт 92 төлөөлөгч, оролцогч оролцлоо.

Одоогоос 16 жилийн өмнө байгуулагдсан Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ нь Монголчууд бидний хувьд гуравдагч хөршийн анхны томоохон хөрөнгө оруулалтын гэрээ байсан. Бидний хувьд онож алдсан зүйл олон байсан ч энэхүү том

бүтээн байгуулалтыг дэлхийн хэмжээний компанитай эхлүүлсэнд талархалтай хандах болно.

Өнгөрсөн хугацаанд Оюутолгой төслийн санхүүжилт, зээлийн нөхцөл, менежмент, засаглалын асуудалд төдийлөн анхаарахгүй, зөвхөн хөрөнгө оруулалтаа ярьсаар анхны амлалт, бодит байдал 2 өнөөдөр тэнгэр, газар шиг зөрүүтэй болсныг нийтээрээ харлаа. Тухайлбал, анхлан тохирсон Монголын талын 53 хувь, хөрөнгө оруулагч талын 47 хувийн үр өгөөжтэй байна гэсэн тооцоолол алдагдаж, хөрөнгө оруулагчдад найдсан Монголчуудын итгэл мөн алдрахад хүрэв. Бүхэлдээ энэхүү гэрээ нь урт хугацааны харилцан ашигтай байх, тэгш зарчимд нийцээгүй, хөрөнгө оруулагч талдаа хэт давуу боломж олгож, баялгийг эзэмшигч Монголын ард түмэнд хүртэх өгөөж, үр ашиг алдагдаж байгаа учир цаг алдалгүй нөхцөл байдлыг эргэн харж, нийгмийн хүлээлтэд нийцүүлсэн өөрчлөлт хийх цаг болсон нь нээлттэй сонсголоор харагдлаа.

Хянан шалгах түр хорооны хянан шалгалтын үйл ажиллагаа 2025 оны 12 дугаар сарын 8, 10, 12-ны өдрүүдэд явуулсан нотлох баримтыг шинжлэн судлах сонсголоор танилцуулсан хянан шалгагчийн тайлан, шинжээчийн дүгнэлт, сонсголд оролцсон гэрчүүдийн мэдүүлэг, тайлбар авч, тусгай шалгалтаар иж бүрэн хэрэгжүүлэн дараах нэгдсэн санал, дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1 дүгээрт, хөрөнгө оруулагч талтай гэрээ байгуулах зарчим, удирдамжийг тодорхойлсон Улсын Их Хурлын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны тогтоол, бодлогын баримт бичгүүдийг баримтлан ажиллаагүйгээс Монгол Улсын хуульд нийцээгүй шийдвэр, үйл ажиллагаа давтагдаж, Монголын талд ашиггүй нөхцөлийг бий болгож иржээ.

2 дугаарт, Улсын Их Хурлын 2008 оны 40 дүгээр тогтоол, 2009 оны 57 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлүүд нь үр ашигтай хөрөнгө оруулалтын гэрээ болон хувь нийлүүлэгчийн гэрээ байгуулах боломжийг олгосон боловч Засгийн газраас гэрээ байгуулахдаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцээгүй, шаардлагыг хангуулаагүй нь Монголын талын Оюутолгой төслөөс хүртэх өгөөжид сөрөг нөлөө үзүүлсэн байна.

3 дугаарт, эрх бүхий байгууллагаас батлуулсан техник-эдийн засгийн үндэслэлгүйгээр гэрээ байгуулах, төслийн санхүүжилтийн олон жишиг хэлбэрүүдээс хамгийн ашиггүй хувилбар болох өндөр хүүтэй зээлийг сонгох, шийдвэр гаргах үйл явц Монголын талын оролцоо, гэрээг хязгаарласан нь хөрөнгө оруулагч талд давуу байдлыг бий болгох, өгөөж хүртэх хувь хэмжээг гэрээнд баталгаажуулаагүй зэрэг нь 20 тэрбум ам.долларын өр хуримтлагдан Монголын талын ноогдол ашиг авах хугацааг тодорхойгүй байдалд хүргэжээ.

Төслийн хэрэгжилтийн явцад Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн аудитын байгууллагаас ажлын хэсгийн хүрээнд санал, дүгнэлт, зөвлөмж гаргасан боловч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй, бодит үр дүнд хүрээгүй байна.

Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй, бүрэн хэрэгжсэн арга хэмжээ байхгүй, 2021 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилт удаашралтай байгаа тул хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай.

Төсөлтэй холбоотой баримт мэдээллийг нууцалж, төр олон нийтийн хяналтаас гадуур байлгах сонирхол, хандлага хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үеэс хэвшиж тогтсон байна. Төсөлтэй холбоотой шийдвэр баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд нууцаас гаргаж, ил болгох, цаашид нийтэд нээлттэйгээр мэдээлэх зарчмыг баримталж, харилцан ойлголцол, итгэлцлийг урт хугацаанд бүрдүүлэх шаардлагатай.

Дээрх дүгнэлтийг үндэслэн Хянан шалгах түр хорооноос Оюутолгой бүлэг ордын хүртэх үр, өгөөжийг нэмэгдүүлэх зорилтыг богино хугацаанд бодитой хэрэгжүүлэх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1 дүгээрт, стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой бүлэг ордын талбайн хил заагт орших Жавхлант, Шивээ толгой ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой шийдвэр, ажиллагааны хууль зүйн үндэслэл хуульд нийцсэн байдлыг нягтлах, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлүүдийг цуцлах хүртэл арга хэмжээ авах, ашиглалтын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох санал боловсруулах. Ирээдүйд Монголын тал хүртэх үр өгөөжид сөрөг нөлөөлөл, үр дагавар бүхий санхүүжилт, хөрөнгө оруулалтын аливаа үүрэг, хариуцлагыг хүлээхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

2 дугаарт, Оюутолгойн хувь нийлүүлэгчдийн гэрээ, нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосны хэрэгжилтийг харилцан дүгнэх, алдагдсан боломжийн өртгийг тооцоолж дүгнэлт гаргах. Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнд холбогдох бусад гэрээ, эрх зүйн баримт бичгийг нийцүүлэх, хувь нийлүүлэгчийн болон гуравдагч этгээдийн санхүүжилтийн хүүгийн хувь хэмжээг зах зээлийн зарчим, жишигт нийцүүлэн бодитоор бууруулах;

3 дугаарт, стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой бүлэг ордын геологи, судалгааны ажлыг үргэлжлүүлж, үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх замаар тус ордын үнэ цэнийг нэмэгдүүлэх, ашиглалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг бас сайжруулах;

4 дүгээрт, Монголын талын үр өгөөжийн хувь хэмжээ 53-аас доошгүй байх нөхцөлийг баталгаажуулан холбогдох гэрээнд тусгах, Оюутолгой компанийн жилийн тайланд талуудад ноогдох үр өгөөжийн тооцоог тусгайлан тайлагнах, уг хувь хэмжээ 5 жил тутам харилцан хянан үзэх зарчмыг нэвтрүүлэх зэрэг болно.

Хяналт шалгалтын үйл ажиллагаа амжилттай болгоход нэгдмэл бодлогоор тууштай дэмжиж хамтран ажилласан Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Эрхэм гишүүд, Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо болон Монгол Улсын Засгийн газрын ажлын хэсгийн гишүүдэд талархал илэрхийлье.

Хянан шалгах түр хорооноос санаачилсан Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай хяналт шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төслийг Улсын Их Хурал хэлэлцэж, баталснаар Монгол Улсын эрх ашиг хангагдана гэдэгт Хянан шалгах түр хорооны зүгээс бүрэн итгэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулагдсан Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх хянан шалгах түр хороо бүрэн эрхээ хэрэгжүүлж, санал, дүгнэлтээ танилцуулсан тул түр хороог татан буугдсанд тооцож, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ чин сэтгэлээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Н.Учрал:** Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлтийг Батнайрамдал гишүүн та бүхэнд танилцууллаа. Горимын санал. Баттөмөрийн Энхбаяр.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын Хяналт шалгалтын түр хороо хуралдаад, тайлан, дүгнэлтээ гаргаад, Улсын Их Хурлын чуулганд танилцуулснаар татан буугддаг. Шаардлагатай гэж үзвэл холбогдох Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг танилцуулдаг. Тэгэхээр түр хороо маань ажиллаад, хуралдаад, тайлангаа гаргаад Улсын Их Хурлын тогтоолын төсөл оруулж танилцуулж байгаа юм байна. Тэгээд энэ тогтоолын төсөл лав л миний урд танилцуулагдаагүй байна. Лав одоогоор. Ямар тогтоолын төсөл бид баталъя гэж байгааг би мэдэхгүй байна. Тэгээд тараасан юм уу, үгүй юм уу. Хэзээ тараасан юм. Үгүй ээ, үгүй. Хэзээ тараасан юм. Өнөөдөр үү. Тэгвэл энийг танилцмаар байна. Судлах 1 дүгээрт бололцоо олгомоор байна.

2 дугаарт энэ Улсын Их Хурлын дэгийн хууль, Хяналт шалгалтын хуулиар би өмнөх парламентын үед ажиллаж байхад энэ тогтоолын төслийг нь Эдийн засгийн байнгын хороогоор танилцуулж байсан байхгүй юу. Манай Хөгжлийн банк болон Нүүрсний хяналт шалгалтын түр хороо Улсын Их Хурлын тогтоолын төслөө Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлж байсан юм. Тэгээд чуулганд орж ирж байсан юм. Одоо шууд тогтоолын төсөл дээр Их Хурал бусад түр хорооноос бусад Их Хурлын гишүүд тогтоолын төсөлтэй холбоотойгоор санал гаргах эрх, боломжгүй болчихоод байна л даа. Одоо энэ заалтыг нь ингэж өөрчилъе гэдэг юм уу, энэ заалтыг нь ингэе гэдэг тэр Улсын Их Хурлын гишүүний санал гаргах эрх хязгаарлагдчихаад байна. Тэгэнгүүт түр хорооноос орж ирсэн тогтоолыг эсвэл батал эсвэл битгий батал гэдэг сонголтыг шууд тулгачхаад байна л даа. Санал гаргах. Үгүй ээ, үгүй би яриад байна шүү дээ. Санал гаргах эрхийг нь хязгаарлачихаад байна. Түр хороо бол тогтоолын төсөл санаачлах эрхээ эдэлчхээд байгаа юм. Их Хуралд танилцуулчихаад байна шүү дээ. Тогтоолын төслөө санаачлаад, түр хороогоороо хэлэлцээд, санаачилчихсан. Тэр дээр түр хорооноос бусад гишүүд нь тэр тогтоолын төсөл дээр санал гаргах, тэр эрхээ хаана, яаж эдлэх вэ. Энэ эрхээ Их Хурлын гишүүд, бусад Их Хурлын гишүүд. Тийм асуудал үүсчхээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр Батнайрамдал аа, миний хөгшин хөөе битгий зөрүүдлээд бай. Би Их Хурлын 110 гишүүний Улсын Их Хурлын шийдвэр дээр санал гаргах Үндсэн хуульд заасан эрхийн тухай яриад байна. Зөв буруугийн тухай яриагүй байгаа юм. Тэгэхээр энэ эрхийг нь хангаж байж яахгүй бол хэдэн хуудас Их Хурлын шийдвэрийн төсөл байгаа юм. Тэр 100 заалттай тогтоолын төсөл дотор 1 заалт дээр жишээлбэл 1 хууль тогтоогч саналтай байж болно шүү дээ. Бусад 99 заалтыг нь дэмжиж байж болно шүү дээ. Зөвхөн тэр 1 заалтыг нь дэмжихгүй, би хасах санал гаргаж болно шүү дээ. Тэгэхээр ингээд шууд тулгаад байгаа байхгүй юу. Эсвэл энийг бүгдийг нь

батал гэдэг ийм сонголт өгөөд, Их Хурлын 110 гишүүний эрхийг хязгаарлачхаад байгаа байхгүй юу. Би энийг яриад байгаа юм. Энийг яаж шийдэх вэ гэдэг асуулт байгаа юм. Тийм учраас энийг тайланг бол одоо танилцчихсан, сонсчихсон. Тэр тогтоолын төслийг холбогдох Байнгын хороодоор хэлэлцэх боломж олгож, Улсын Их Хурлын бусад гишүүдийг санал гаргах, Үндсэн хуульд заачихсан тэр эрхийг нь эдлэх бололцоогоор олгооч ээ л гэдэг ийм горимын саналтай байна.

**Н.Учрал:** Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр Их Хурлын Хянан шалгах хороо бол энэ сонсголттой холбогдуулаад ажилласан хугацааныхаа, 6 сарын хугацааныхаа тайлан, санал, дүгнэлт, холбогдох шийдвэрийн төслийг Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна гэдэг л эрхийг өгсөн. Тэгэхээр Энхбаяр гишүүний хэлж байгаагаар танилцуулсны дараа хэлэлцэх процесс бол тусдаа асуудал. Их Хурлын Хянан шалгах түр хороо бол тайлангаа танилцуулаад ийм шийдвэр оруулъя гэдгээ Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна. Энэ цаг үе мөчөөс хойш бол тус шийдвэрийн төслийг нь чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу тэр Байнгын хороогоор оруулаад, хэлэлцээд батлах буюу Их Хурлын гишүүд тэр шийдвэрийн төсөл дээр санал гаргах эрхийг нь олгохгүй бол шууд Хянан шалгах түр хороо Их Хурлын тогтоол оруулж ирээд, чуулганаар кнопдоно гэвэл энэ бол өөрөө бид бас дэгийнхээ хуулийг зөрчих ийм л эрсдэл байгаа байхгүй юу Батнайрамдал гишүүн ээ.

Үгүй ээ, үгүй. Ер нь бол би 1 зүйлийг хэлье. Батнайрамдал гишүүн Хянан шалгах түр хороог ахлаад, олон нийтийн мэдэх эрхийг хангуулаад, 3 өдрийн туршид энэ сонсголыг маш өндөр зохион байгуулалттайгаар хийлээ. Олон нийт энэ Оюутолгойн гэрээтэй холбоотойгоор маш олон мэдээллүүдийг авлаа. Шүүмжлэл эргэцүүллээ. Холбогдох гэрчүүд, холбогдох албан тушаалтнууд, ажлын хэсгийнхэн оролцлоо.

Тэгээд Батнайрамдал гишүүний ахалсан энэ Хянан шалгах түр хороо бол үнэхээр дэвшилтэт ийм ажил боллоо. Тэгээд Батнайрамдал гишүүнээр ахлуулсан энэ Хянан шалгах түр хорооны гишүүдэд бас баяр хүргэе. Энэ бол сайн ажил боллоо. Одоо би цаашдаа яах вэ гэж, Батнайрамдал гишүүн түр хорооныхоо тайланг тавьчихлаа. Шийдвэрийн төслөө танилцуулчихлаа. Тараагдчихлаа. Одоо хэлэлцэх процесс үргэлжлэх ёстой байхгүй юу. Тамгын газрынхан та нар. Горимын санал дээр Батнайрамдал гишүүн тайлбар хэлэх юм уу. Тэмүүжин гишүүн горимын санал гаргана. Тэгээд Батнайрамдал гишүүн тайлбараа хэлье. Тэгээд эцэслэх хэрэгтэй. 1 сарын 2-нд Хянан шалгах түр хорооны хугацаа дуусах юм. Түүнээс өмнө бид нар шийдвэрийн төслөө дэгийнхээ хуулийн дагуу батлах ёстой. Тэмүүжин гишүүнд микрофон өгье.

**Х.Тэмүүжин:** Энэ Хянан шалгах түр хороо байгуулах гарын үсэг зурсан гишүүний 1 нь би өөрөө байгаа. Хянан шалгах түр хорооны сонсгол зохион байгуулж байгаа үйл ажиллагааг бүтэн 3 өдрөөр нь бас нэлээн няхуур харж, телевизээр харж суусан. Энэ болж байгаа процесстой холбогдуулаад үнэхээр 3 үг хэлмээр санагдаад байсан.

1 дүгээрт бид бас жоохон зоригтой алхах ёстой байсан юм байна. Дэлхий нийтээрээ парламент энгийн хяналтаар шалгаж чадахгүй зүйлийг шалгахын тулд Мөрдөн шалгах түр хороо байгуулдаг. Бид мөрдөн шалгах гэдэг үгнээс тойрч зугтаагаад, хянан шалгах гэдэг үг хэрэглэчихсэн. Мөрдөн шалгах гэдэг агуулга нь юуг илэрхийлдэг вэ гэхээр мэдээлэл гаргаж өгөхгүй байгаа байгууллагуудад

нэвтэрч ордог тусдаа парламентын прокурор буюу парламентын бие даасан шинжээч гэдэг албан тушаалтныг томилж байгаад, тэр мэдээллүүдийг парламент өөрөө авдаг. 1 дүгээрт нь.

2 дугаарт нь хэрвээ тэр мэдээлэлд нууцтай холбоотой ч юм уу эсвэл хаалттай байгаа бол парламент өөрөө нууцаас гаргах эрхтэй байдаг.

3 дугаарт нь хэрвээ нууцаас гарах үнэхээр шаардлага, нууц байх шаардлагатай тийм мэдээлэл байгаа бол хаалттай хуралдаж байгаад, бүрэн дүүрэн мэдээлэл авч байгаад, дүгнэлт мэдээллээ боловсруулдаг. Тэгээд сая бид яасан бэ гэхээр энэ хянан шийдвэрлэх гэдэг нэрийг хэрэглэчихсэн учраас парламентын ерөнхий хяналтаасаа ерөөсөө ялгарсангүй. Нууцад авсан, өгөхгүй байгаа мэдээллүүдийг нэвтэрч авч чадсангүй. Нууцад байгаа мэдээллүүдээ хаалттай юм уу, эсвэл бол нээлттэй болгож байгаад бас сонсголоор авч чадсангүй. Зөвхөн 1 хэсгээр нь ил байгаа мэдээлэл дээр сонсгол хийж байна гэж сонсгол зохион байгуулж байгаа хүмүүс дахин дахин хэлэх байдлаар энэ мэдээллийг авсан. Ингэхээр Оюутолгойтой холбоотой асуудал чинь бүрэн дүүрэн сонссон юм уу. Парламент хаалттай болон нээлттэй сонсдог. Ямар нэгэн байдлаар сонсох ёстой. Хаалттай сонсоогүй мэдээллүүд чинь парламент руу орж ирэх юм уу. Энэ улс 126 гишүүн дээр энэ мэдээллүүд чинь байх юм уу. 126 гишүүн бүрэн мэдээлэлтэй шийдвэр гаргах юм уу гэдэг дээр эргэлзээ төрсөн.

2 дугаарт бид яах аргагүй энэ дэг дээрх зарим зүйлээ зохицуулахгүй бол нууцаас гаргадаггүй, нууц материалуудыг ил болгодоггүй эрхтэй парламент гэж байхгүй шүү дээ. Эрхгүй парламент гэж. Засгийн газар нь тийм эрхтэй байж байдаг. Парламент нь тийм эрхгүй байж байдаг. Тусгай хяналтын дэд хороо болон тэрэнтэй холбоотой дэд хороонуудынхаа санал, дүгнэлтийг үндэслээд, нууцаас гаргадаг эрх мэдэлтэй парламент болох ёстой шүү дээ. Тэр дотор чинь гэмт хэргүүд, зарим талдаа компанийн буюу бизнесийн нууц гэдгээр халхавчилсан Засгийн газрын Монгол ард түмний мэдэх ёстой эрх мэдлийг хязгаарласан мэдээллүүд байна лээ шүү дээ. Тэрийг нь ил болгож чаддаггүй парламент байна гэдэг чинь нөгөө Үндсэн хуульд байгаа төрийн эрх барим дээд байгууллага Монгол Улсын гадаад, дотоод бодлогын асуудлыг бүгдийг нь шийдэх эрх мэдэл гэдэг чинь бодитойгоор байхгүй байна гэсэн үг шүү дээ.

Дахиад нэг юм. Яагаад нөгөө улс орнуудад чинь парламентын бие даасан прокурор гэж хэлээд байгаа юм. Яагаад парламентын бие даасан шинжээч гэж хэлээд байгаа юм гэдэг чинь тэр байгууллагууд руу төрийн байгууллага байна уу, хувийн байгууллага байна уу. Хамаагүй мэдээллийг нь нэвтэрч ороод авдаг байгууллага эрх мэдлийн тухай ярьж байгаа шүү дээ. Тэгснээс биш гуйж царайчлаад өгөхгүй байгаа юм гэж сууж байдаг парламентын тухай яриа биш шүү дээ. Тэгэхээр энэ талаарх хууль тогтоомжоо боловсронгуй болгох ёстой юм байна. Юмыг авсан бол авсан шиг авах ёстой юм байна гэж харагдаж байгаа юм.

2-т нь Батнайрамдал аа, битгий хямар. Улсын Их Хурлын шийдвэр гаргах гэж байгаа бол тэрийг чинь мэргэжлийн Байнгын хороо авч хэлэлцэнэ. Хууль зүйн ньюанстай асуудлыг Хууль зүйн байнгын хороогүйгээр шийдэх гэж байна гэж болохгүй шүү дээ. Эдийн засгийн байнгын хороо бас яг адилхан байхгүй юу. /минут дуусав/

**Н.Учрал:** Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Бас олон мянган Монголчууд бас харж байгаа болов уу гэж бодож байна. Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар явж байгаа анхны Хянан шалгах түр хороо бол Оюутолгой дээр байгуулагдсан энэ хянан шалгах түр хороо. Алдаа, оноо байхыг үгүйсгэхгүй ээ. Гэхдээ Хянан шалгах түр хороо хуулийнхаа хүрээнд, боломжийнхоо чадлаар бүхнийг хийсэн. Давуулан биелүүлэх гэж оролдсон. Таны хэлж байгаа Тэмүжин гишүүн үнэн л дээ. Англиар бол энэ чинь уул нь investigative committee байхгүй юу. Мөрдөн байцаах эрхтэй. Бид нар л хяналт шалгалт гээд орчуулчихсан болохоос. Ард түмнийг мэдэх эрхийг хангахыг гол зорилгоо болгосон. Бас ийм асуудал байгаа юм байна гэдгийг бүгдийг нь дэвшүүлж, ямар нэгэн лобби орохгүйгээр хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр гаргах гэж бид нар бүх талаас нь хичээсэн. Тэрийгээ ч бид нар бахдалтайгаар хэлж чадна. Өнөөдөр хурлаар оруулах гэж их юм боллоо. Амаргүй юм байна. Гэхдээ та бүхнийгээ ойлгож байна бас. Бид нар хуулиа бол ягштал дагасан. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар ер нь Хянан шалгах түр хороо бол зүгээр 1 хуулиар олгосон эрх биш шүү. Энэ Үндсэн хуулийн 28.2-т заасан Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхээ бид нар хэрэгжүүлсэн.

Хяналт шалгалтын тухай хуулийн 55.1 дээр түр хорооны тайлан энэ дээр бол Хянан шалгах түр хороонд холбогдох шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд танилцуулна гээд байгаа юм. Бид нар хуулийнхаа хүрээнд л танилцуулах гэж оруулж ирсэн. Энэ чинь Хянан шалгах түр хороо шүү дээ. 1 ажлын хэсэг биш. Хянан шалгах түр хороо. Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхтэй. Гэхдээ одоо Улсын Их Хурлын ямар ч байсан тайлангаа бид нар ингээд та бүхэндээ өргөн барилаа. 2 тайлан байгаа. 200 хуудас тайлан. 200 хуудас дахиад презентац. Нийтдээ 400 хуудас материалыг, 94 мянган хуудас материалаас бид нар гаргаж авсан.

Тайландаа бид нар ямар ч байсан сэтгэл хангалуун байгаа. 5 жилийн дараа, 10 жилийн дараа бид нар хэлэх үгтэй гэж бодож байгаа. Энэ дээр яг мэргэжлийн түвшинд ямар нэгэн нөлөөлөлгүйгээр ажилласан хянан шалгагч, шинжээчид бол яг энэ бүх зүйлийг нуруун дээрээ авч гарсан хүмүүс. Тэгээд бүгдээрээ та бүхэн горимын саналаа гаргаад, хэрвээ яваад Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэе гээ байгаа бол тэр дээр нэг их татгалзаад байх юм байхгүй. Хэлэлцүүлээд явж болно.

Гэхдээ миний энэ 5 сарын туршид олж харсан зүйл юу гэх юм бол маш их нөлөөлөл оруулах гэсэн оролдлогууд та бүхэн бүгдээрээ сошиалаар дүүрэн харлаа шүү дээ. Сүүлдээ би юу ч болоод явчхаж байгаа юм. Гэхдээ ганцхан зүйл байгаа. Энэ дээр Монгол Улсын эрх ашиг л гэсэн ганцхан зүйл байгаа шүү. Энэ дээрээ бид нар үзэл бодол зөрсөн хамаарахгүйгээр бүгдээрээ хамтдаа бат зогсоод, Оюутолгой төсөл дээр шинэ эринийг эхлүүлчхээсэй л гэж энэ хэдэн залуучууд нь чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Тэгээд хүрээ хязгаарынхаа хүрээнд бидний танилцуулсан энэ тогтоолын төслийг агуулгыг тэр чигээр нь өөрчилчихгүйгээр, дараа нь ямар ч хэрэгжих боломжгүй зүйл болгочихгүйгээр бүгдээрээ энийгээ дараа нь 5 жилийн дараа, 10 жилийн дараа бас түүхэн тогтоол байсан шүү гэж хэлэхээр батлаад өгөөрэй гэж та бүхнээсээ Монголын нийт ард түмний өмнөөс гэж.../минут дуусав/

**Н.Учрал:** Батнайрамдал дарга аа, Их Хурал таны түр хороог бүрэн дэмжсэн шүү. Одоо ч дэмжиж байна. Оруулах гэж зовоод байх юм байхгүй. Өчигдөр шөнө 1:30 хүртэл хүлээсээр байгаад, шөнийн 1:30-д даргын зөвлөл дээр өөрийн чинь

хэлэлцэх асуудлыг энэ Байнгын хорооны дарга нар бүгдээрээ дэмжээд оруулсан. Тэгээд ганцаараа шударга хүн, бусад нь хулгайч юм шиг ингээд ярихаа болино шүү. Одоо ер нь хэдүүлээ бас ... бид Их Хурал бүрэн дэмжиж байгаа шүү. Их Хурал таны түр хорооны сонголыг 3 өдөр зохион байгуулалцсан. Бүх юманд нь дэмжсэн. Өчигдөр шөнийн 1:30 хүртэл харсан. Тэгээд та надад хэлэхээр нь би даргын зөвлөл дээр дэмжүүлье гээд өнөөдөр ингээд өөрөө энд оруулаад ирж байгаа юм.

Тэгээд шийдвэрийн төслийг олон нийтэд биш, нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэгтэй. Шийдвэрийн төслийг хэлэлцээд батлах талд бүх Их Хурлын гишүүн байгаа. Улс эх орныхоо эрх ашгийн талд хамт байгаа. Харин тогтоолын төслөө чангаруул, илүү хариуцлагатай заалтууд оруул гэж Даваасүрэн гишүүн, Тэмүүлэн гишүүн, олон гишүүд хэлсэн. Алтанхуяг дарга хэлсэн. Тийм юм байгаа. Тэрнээс биш одоо энд Засгийн газар одоо энэ Оюутолгой дээр хэлэлцээр хийгээд явж байгаа. Зээлийн хүү бууруулах асуудлаар, ер нь бүгдээрээ л хичээж байгаа шүү. Тийм учраас Батнайрамдал даргын энэ түр хороог бол би бүрэн дэмжиж байгаа. Тэрнээс биш зовж орууллаа энэ тэр гээд бас нэг тийм. Тэгээд одоо ингэе.

Оюутолгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлсэн энэ тайлан, мэдээллийг бид нар сонссон гэж ойлголоо.

Тэгэхээр үргэлжлүүлээд хэлэлцээд энэ тогтоолын төслийг шууд хэлэлцэж явах уу, үгүй юу гэдэг ийм асуудлын өмнө нүүр тулчхаад байна. Тэгэхээр Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт болон энэ төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх ... түрүүн Энхбаяр гишүүнийхээс өөр горимын санал биз дээ.

Бямбацогт сайд горимын санал хэлнэ.

**С.Бямбацогт:** Батнайрамдал гишүүн бас ингэж их попорч болохгүй л дээ. Их гоё ярьсан нь, их хөмсгөө зангидсан нь, дуу хоолойгоо шахсан нь эх оронч байдаггүй шүү. Бүгдээрээ л бас энэ Оюутолгойн төслийг сайжруулахын төлөө үе үеийн Улсын Их Хурлын гишүүд, үе үеийн засгийн газрууд чадлаараа л ажиллаж байгаа, чадлаараа ажиллах болно цаашдаа. Одоо ч гэсэн Засгийн газар энэ зээлийн хүүг бууруулах, менежментийн төлбөрийг орлого, үр дүнгээс суурилдаг болох, зардал дээр суурилдаг биш, менежментийн төлбөрийг бууруулахын төлөө ажиллаж л байна. Арбитрын шүүх дээр бас ажиллаж л байна. Тэгж байхад ганцаараа их мундаг ажилладаг, урьд өмнө нь ажиллаж байсан Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд ч муу ажиллаж байсан. Одоо энэ Их Хурлын 126 гишүүн огт ажиллахгүй байгаа, Засгийн газар юу ч хийхгүй байгаа юм шиг, ганцаараа эх оронч юм шиг ингэж бас болохгүй. Би танаас түр хорооны тогтоол, мэдээлэл өгөөч ээ гэж зөндөө гуйсан. Та өгөөгүй. Засгийн газар бас байр сууриа бас илэрхийлмээр байна. Энэ дээр чинь ямархуу юм орж байгааг нь мэдмээр байна гэсэн чинь нууц гээд өгөөгүй. Тэгэнгүүтээ та гэнэт өнөөдөр чуулганд оруулж ирж тарааж, хэлэлцүүлэх гэж байна. Ингэж болохгүй шүү дээ. Тэр тогтоол чинь юу байгааг бид нар мэдэх эрхтэй биз дээ. Хамтраад Засгийн газар, Их Хурал 1 байр суурьтай, Монголчууд бүгдээрээ л 1 бодлоготой, 1 зорилготой, 1 Монголчууд шүү гэж би танд зунаас хойш 7 сар, 8 сар, 9 сард уулзах бүрдээ хэлж байсан. Энэ Засгийн газрын явуулж байгаа үйл ажиллагаанд л дэм болоосой, тус болоосой. Үүний төлөө л энэ түр хорооны чинь үйл ажиллагаа чиглэгдэх ёстой шүү гэж зөндөө хэлсэн. Гэтэл ингээд нууж байгаад, танилцаадахъя гэхээр танилцуулахгүй, өгөхгүй байгаа шүү дээ. Тэгэнгүүтээ

гэнэтхэн оруулж ирээд өнөөдөр ингээд асуудал хэлэлцүүлнэ гээд ярьж байгаа чинь зохимжгүй байна.

Их Хурлын гишүүд хэлэлцэж байгаа асуудал дээр ямар ч асуудал дээр бүгдэд нь танилцах, өөрийн итгэл үнэмшилтэй болох, өөрсдийнхөө байр суурийг олон нийтэд илэрхийлэх итгэл үнэмшилтэй болох, судлах, унших ийм цаг хугацаа боломжоор хангагдах ёстой. Энэ эрх хангагдахгүй байна шүү дээ. Түр хорооны зөвхөн цөөхөн хэдэн гишүүд нь танилцсан, мэдсэн, уншсан. Бусад 120 гишүүн нь мэдэхгүй. Засгийн газар ямар юу орж байгаа юм мэдэхгүй, асуугаад нэхээд авч чадахгүй. Ингэж хэлэлцүүлж болохгүй.

Тийм болохоор Их Хурлын гишүүдэд танилцах, унших, судлах, байр сууриа илэрхийлэх боломжийг олгох ёстой. Мэргэжлийн Байнгын хороо бас хэлэлцээд, тодорхой санал, дүгнэлтээ гаргах ёстой. Засгийн газар бас түр хорооны тогтоол дээр юу орж байгааг, хэнийг юу гэж буруутгаж байгаа юм. Хэнийг, ямар ажлыг нь яаж зөвтгөж байгааг бид мэдэхгүй байна шүү дээ. Баахан ажил хийчхээд сүүлд нь түр хорооны тогтоол дээр Засгийн газар ажил хийгээгүй байна гээд орчих юм бол бид нар юу гэж хэлэх юм. Ийм байдлаар ингэж бас хандаж болохгүй ээ.

Тийм болохоор Эдийн засгийн байнгын хороо хэлэлцье. Мөн бас Засгийн газрын ажлын хэсгийн гишүүд бас танилцъя. Засгийн газар бас тодорхой энэ тогтоол дээр байр сууриа илэрхийлэх боломжийг бас олгож өгөөч Учрал дарга аа. Тийм болохоор энийг хойшлуулж өгөөч ээ гэж танаас горимын санал гаргаж, хүсэж байна.

**Н.Учрал:** Тэгээд ер нь ихэнх гишүүд бол энэ Их Хурлын гаргаж байгаа тогтоол дээр хэтэрхий их ерөнхий байна. Илүү деталь заамаар байна. Баялгийн сангаа нэмэгдүүлмээр байна. Монгол Улсын эрх ашгийг хангуулсан тодорхой заалт хиймээр байна гэдэг санал гаргаад байгаа шүү. Бүр чангаруулах хэрэгтэй. Тодорхой байх хэрэгтэй гэдэг санал хэлээд байгаа байхгүй юу гишүүд. Түр хороог төлөөлөөд тэгвэл Ганзориг гишүүн хэлээд, тэгээд энэ чинь шийдвэрийн төслөө танилцуулчихсан гэж би ойлгож байна шүү дээ. Горимын санал нь юу байх юм бэ. Хойшлуулъя гэсэн санал юм байна. Ганзориг гишүүн.

**П.Ганзориг:** Би горимын санал гаргасантай холбоотой энэ Хянан шалгах түр хорооны гишүүнээр сүүлийн 6 сар ажилласан гишүүний хувьд бас тодорхой саналаа хэлье. Бид нарын хувьд бол мэдээж энэ 16 жилийн хугацаанд Оюутолгойн төсөлтэй холбоотой гарч байсан шийдвэрүүд, Улсын Их Хурлын тогтоолууд, олон ажлын хэсэг ингээд л өнгөрсөн хугацаанд оролцож байсан бүх л хүмүүсийн өөрсдийн оролцоо, эх орныхоо эрх ашгийг хангах, үндэснийхээ эрх ашгийг хамгаалах чиглэлд гарч байсан зүйлүүдийг бүгдийг нь бас харж танилцаж, алдаж байсан алдаа оноог дүгнэж, энийг 16 жилийн туршид нэг сайн дүгнэж авч байгаад цаашаа яаж эрх ашгаа хангуулах вэ гэдэг дээр санал, дүгнэлтээ гаргаж оруулж ирж байгаа. Тиймээс өчигдрийн Хянан шалгах хорооны хурал дээр ч гэсэн энэ тогтоолын төслөө гаргахдаа нэлээн сайн чангаруулж гаръя гэдэг саналуудыг би бас хэлсэн. Нарийвчилж бас оруулъя зарим заалтуудаа гээд. Тийм болохоор гишүүдээс гарч байгаа санал, Хянан шалгах хорооны дарга ч гэсэн болно гэж байх шиг байна. Холбогдох Байнгын хороогоор ороод явах нь зөв л гэсэн байр суурьтай байж байгаа. Тэр дээр Их Хурлын гишүүд бас сайжруулах санал байвал оруулаад явах ёстой. Тэгээд энэ 1 гараад батлагдчих юм бол нэг хэсэгтээ бас энэ тогтоолоо л бид нар барьж ажиллах болно. Шахаж, шаардаж. Тийм болохоор бол энийг дэмжиж байгаа.

Тодорхой гишүүдээс ч гэсэн бас саналууд ирсэн. Бичгээр ч ирсэн. Бид нар өчигдөр бас авч ярилцсан. Санал, дүгнэлтдээ ч гэсэн уг нь ихэнхийг нь оруулсан. Тэгэхдээ Их Хурлын тогтоолын төсөл рүү бас тэндээс заримыг нь оруулах шаардлага бол харагдаад байгаа юм. Тэгэхээр энийг бол дэмжиж байгаа.

Тэгээд ер нь товчхон бас хэлэхэд энд 11 гишүүн оролцож ажилласан шүү. Нам, намын төлөөллүүд оролцож ажилласан. Сүүлийн 6 сарын туршид. Бүх Хянан шалгах хорооны 13 удаагийн хуралд би өөрөө байнга сууж, бүх ажилд нь орж, энэ асуудлуудыг нь судалж бас бодитой асуудлуудыг нь гаргаж, хэлж ажилласан. Энэ бол бид нарын үүрэг. Их Хурлын гишүүн, дээр нь Хянан шалгах хорооны гишүүдийн үүрэг. Тэгэхээр бас ганцхан Батнайрамдал гишүүн хийгээд ажиллаад байгаа юм шиг бас гишүүд харж болохгүй. Энд бол олон гишүүд, олон намын төлөөллүүд орж, өөрөө өөрийнхөө үүргээр энэ ажлыг бас үр дүнтэй, амжилттай хийж гаргахын төлөө ажилласан гэдгийг хэлье. Баярлалаа.

**Н.Учрал:** Ингэе. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно. 45.4.түр хороонд гэж байна. Түр хороонд.

Батнайрамдал дарга аа, 1 сарын 2-оос өмнө бид нар батална. Үүнд би бүрэн дэмжлэг үзүүлнэ. Тэгээд энэ чинь шийдвэрийн төслөө Батнайрамдал дарга танилцуулчихлаа. Ийм төсөл байна гээд. Энэ төслийг нь Эдийн засгийн байнгын хороогоор оруулаад, Байнгын хорооны гишүүд саналаа хэлээд, Их Хурлын чуулганы хуралдаанаар баталж болно биз дээ. Та нар тодорхой 1 юм ярь л даа. 5, 10 юм яриад байх юм. Өмнөх балаг чинь дуусаагүй байгаа биз дээ. Тамгын газрынхан нэг юм ярь. Хэрвээ би өөрөө ингээд мэдчихдэг юм бол та нар энд хэрэггүй шүү.

Нийслэлийн ерөнхий боловсролын 102 дугаар сургуулийн 12<sup>б</sup> ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч нарт сурлагын амжилт хүсье.

Энэ 45.4. Өөрөө хуулиа хараад, ингээд өөрөө явчих бол Их Хуралд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй юу, үгүй юу. Тийм биз дээ энэ чинь. Та нар тодорхой нэг юм ярь л даа.

Нэгдсэн хуралдаанд өнөөдөр гишүүд горимын саналуудыг гаргалаа. Түр хорооны дарга Батнайрамдал гишүүн, Ганзориг гишүүн, түр хорооны гишүүд дэмжиж байна.

Тийм учраас ирэх 7 хоногийн хэлэлцэх асуудал дээр Эдийн засгийн байнгын хороо, дахиад түр хороогоор аль алинаар нь оруулаад, тэгээд саналаа оруулаад Их Хурлаар тогтоолоо хамт батлаад явъя. Гишүүд бас саналаа гаргах бүрэн эрхтэй. Тэгэхээр 45.4-ийн дагуу өнөөдрийн Түр хорооны тогтоол, шийдвэрийг Байнгын хороонд буцаалаа. Түр хороонд нь буцаалаа. Түр хороонд нь буцааж байна.

Дээрээс нь Эдийн засгийн байнгын хороогоор санал, дүгнэлт гаргуулъя. Тэгээд ингэж шийдвэрлэе. Түр хороогоороо дахиж хэлэлцээд, тэгээд Эдийн засгийн байнгын хорооноос санал, дүгнэлт гаргаад Их Хурлаар батлаад явъя. Тэгээд бүгдээрээ оны өмнө Түр хорооныхоо шийдвэрийг баталъя. Бид бүгдээрээ дэмжинэ.

Батнайрамдал дарга аа, тайван байгаарай. Бүгдээрээ хамтдаа олуулаа хэлэлцээд, асуудлаа шийдвэрлээд гаръя. Сонсголын үр дүн өгөөжөө өгөх хэрэгтэй.

12.52 цаг.

**Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор бас санал хураалт явуулах юм байна.**

Санал хураалт. Энэ эцэслэн баталъя гэсэн саналын томъёолол дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаалаа. Уянга гишүүн, Батнайрамдал гишүүн 2-т талархаж байна. Засгийн газрынхаа ажилд бодлого, дэмжлэг үзүүлж, хууль санаачилж, эцэслэн батлах хүртэл ажилласан явдалд талархаж байна. Баярлалаа.

Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулах ёстой. Энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотой боловсруулсан хууль. Тэгээд энэ санал хураалтыг хойшлуулчих уу. Ирэх 7 хоног хүртэл хойшлууллаа. Санал хураалт хийе.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

12.55 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*